

“ДОРНОД МОНГОЛ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД 2009 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА

**Д.НАВААН¹, Д.ТҮМЭН², М.ЭРДЭНЭ³, Д.ХАТАНБААТАР⁴,
Г.АНХСАНАА⁵**

¹МУИС, НШУС, Археологи-Антропологийн тэнхим

²МУИС, НШУС, Археологи-Антропологийн тэнхим, e-mail: tumen@num.edu.mn

³МУИС, НШУС, Археологи-Антропологийн тэнхим, e-mail: merdene@num.edu.mn

⁴ШУТИС, НТС, Түүх-Аялал жуулчлалын профессорын баг e-mail: hb_parl@yahoo.com

⁵БХЯ, Монгол Цэргийн Музей, e-mail: g.anhaa@gmail.com

Түлхүүр үгс: Азийн судалгааны төв, Улаан Зуух, Цагаан чулуут, дөрвөлжин булш, шинэ чулуун зэвсэг, хүрлийн үеийн дурсгал, монголын үеийн дурсгал, түрүүлгэ нь харуулж оршуулах зан үйл

ТОВЧ АГУУЛГА: Дорнод Монгол төслийн хүрээнд 2009 оны хээрийн судалгааг Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Мөнххаан, Хэнтий аймгийн Баян-Овоо, Дорнод аймгийн Булган, Гурванзагал, Сэргэлэн сумдын нутагт зохион явуулж нийт 17 булш, чулуун зэвсгийн үед холбогдох 1 бууц сууринг малтан шинжиллээ. Хээрийн судалгааны явцад малтан шинжилсэн Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Улаан зуухан хэмээх газарт орших түрүүлгэ нь харуулж оршуулах өвөрмөц зан үйл бүхий булшнууд нь хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин болон шоргоолжин булшны соёлын харилцан хамаарал, тэдгээрийн он цаг, угсаа гарвалын асуудлыг судлахад чухал ишжим болно.

Мөн Дорнод аймгийн Гурванзагал сумын нутаг Цагаан чулуутад малтан шинжилсэн Монголын үеийн булшнаас илрүүлсэн эд өлөгийн зүйлс нь Монгол болон Өвөрбайгалын дундад эртний нүүдэлчдийн соёл, зан заншил, шашин шүтлэг, нийгмийн байдлыг харуулах чухал эх хэрэглэгдхүүн болж байна.

МУИС-ийн Археологи-Антропологийн тэнхим тус сургуулийн дэргэдэх Азийн судалгааны төвийн санхүүжилтээр “Дорнод Монгол” судалгааны төслийн хүрээнд жил болгон Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн нутагт археологийн хээрийн судалгаа явуулдаг билээ. 2009 оны хээрийн судалгааг 2009 оны 6-р сарын 22-оос 7-р сарын 22 хүртэл хугацаанд зохион явууллаа.

Хээрийн судалгааны явцад Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Булгийн эх, Их хөмөг, Бичигт, мөн аймгийн Мөнххаан сумын нутаг Ачаат уул, Барга элс, Устай Бургастай, Дорнод аймгийн Гурванзагал, Сэргэлэн сумдын зааг

нутаг Хөцөөт, Хэнтий аймгийн Баянмөнх сумын нутаг Зайсан толгой зэрэг газруудад археологийн хайгуул явуулж, түүхийн олон үед холбогдох булш оршуулга, хадны бичээс, зураг, чулуун зэвсгийн бууц, хотын туурь зэргийг илрүүлэн олж баримтжуулалт үйлдлээ. Үүнээс гадна Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Улаан зуухад 5, Их хөмөгт 1, Мөнххаан сумын нутаг Устай Бургастайн Барга элсэд 1, Дорнод аймгийн Булган сумын нутаг Холбоо толгойд 3, Гурванзагал сумын нутаг Цагаан чулуутад 6, Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутаг Майхан толгойд 1 булш, нийт 17 булш малтан шинжилснээс гадна Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг Устай Бургастайн неолитийн үеийн бууцанд бага хэмжээний сорилтын малтлага, судалгааг хийж гүйцэтгэв.

СҮХБААТАР АЙМГИЙН ТҮВШИНШИРЭЭ СУМЫН НУТАГТ ЯВУУЛСАН АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА

ХАЙГУУЛ СУДАЛГАА

Хээрийн судалгааны явцад Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутагт нарийвчилсан хайгуул хийсний дүнд Халх хошуу хэмээх газар археологийн өвөрмөц дурсгал илрүүлэн олов. Уг газар орших хүннү, Монголын үед хамаарах булш болон бусад дурсгалыг дараа жилийн хээрийн судалгаагаар нарийвчлан судалж байршлын зураглал, он цаг соёлын хамаадлыг тодорхойлох зорилго тавилаа.

ИХ ХӨМӨГИЙН АМ (ЭНГЭРИЙН БУУЦ)

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг, Дэлгэрхаан уулын баруун урд доор орших задгай урт амыг нутгийнхан Их хөмөгийн ам хэмээн нэрийдэх ба түүний төгсгөл хормой хэсгээр түүхийн янз бүрийн үед хамаарах олон тооны булш шигүү байрлажээ. Археологич З.Батсайхан 2000 онд МУИС-ийн Археологи-Антропологийн тэнхмийн оюутнуудтай энд Хүннүгийн үед холбогдох булш малтан судалж зарим үр дүнг нэгэн сэдэвт бүтээлдээ тусгахдаа Энгэрийн бууц хэмээх нэрээр тэмдэглэсэн байдаг. (2002: 33). Тэрээр энд зөвхөн хүннү төдийгүй хүрэл зэвсгийн үед холбогдох дөрвөлжин булштай ижил гадаад зохион байгуулалт бүхий булш тохиолддогийг бас тэмдэглэжээ (2002: 32). Бидний ажигласнаар энд мөн Монголын үед холбогдох булш ч тохиолдож байна. Бид энэхүү газарт байх бүлэг оршуулгын байршлыг тогтоон, тодорхойлолтыг хийж гүйцэтгэв. Энд түүхийн олон үед холбогдох нийт 156 дурсгал бүртгэж, баримтжууллаа.

Энгэрийн бууцанд цагариг, дугуй хэлбэрийн булш дийлэнхийг эзлэх ба зарим дугуй хэлбэрийн чулуун дараастай булшны зүүн болон зүүн урд талд хөшөө чулууд байна. Мөн тус оршуулгын газрын төв хэсэгт орших булшнууд нь уулын үерийн улмаас дараас чулууд зөөгдөн ихэд эвдэрч, гадаад зохион байгуулалтыг танихад төвөгтэй болсон байв. Энэхүү оршуулгын газар нь олон үеийн дурсгал

цогцолбороор орших чухал дурсгал болох бөгөөд байгалийн эвдрэлд орон устах аюултай байгааг анхааран яаралтай малтан судалбал зохилтойг тэмдэглэж байна.

Мөн Дэлгэрхаан уулын баруунтай Цагаан элэгийн хадны зураг хэмээх 50 орчим хадны сийлмэл зурагтай дурсгал орших ба уул дурсгалыг археологич З.Батсайхан Хүннүгийн үед хамаарна хэмээн үзэж, хадны сийлмэл зургийн дорнод хязгаар хэмээжээ (Батсайхан нар, 1998: 16-25).

БУЛГИЙН ДОВЖОО

N 46° 37' 16.9"

E 111° 45' 48.7" Alt 1070 m

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Дэлгэрхаан уулын баруунаар их дэрсэн дундуур урсах бага шиг голыг Булгийн гол гэх ба түүний тохой Булгийн эх хэмээх газарт хэлбэр хийцийн хувьд Мөнххаан сумын нутагт орших Сүмийн довжоотой адил 4 байгууламж байх ажээ. Уг байгууламжийг нутгийнхан “Булгийн довжоо” гэх ба өөр хоорондоо 300-500 метрийн зайтай оршиж байв (Гэрэл зураг 1). Довжооны орчим хайгуул хийхэд саарал өнгийн дээврийн ваар их хэмжээгээр олдож байв. Мөн энэ орчмоос ваарны хагархайг засаж янзлан хийсэн хөлөгт тоглоомын хасаа түүврээр олдов.

Үүнээс гадна голын зүүн эрэг дагуу олон тооны дөрвөлжин болон шоргоолжин булшнууд тохиолдсоныг бүртгэн авлаа. Ингэхдээ төв буюу хамгийн том байгууламжаас хойш самнан хайгуул хийж дурсгалуудыг бүртгэв. Нийт 46 булш тоологдсон ба гадаад зохион байгуулалтын хувьд ойр орчимд тохиолдох дөрвөлжин булшны зохион байгуулалттай ижил хэдий ч зарим нэг онцлог зүйл ажиглагдсан болно. Зарим булшны толгой буюу зүүн талд нь ойролцоогоор 5-10 орчим метрийн зайд түрэгийн үеийн зэл чулуудын адил олон тоогоор зоосон хөшөө чулууд тохиолддог нь сонирхол татаж байв. Эдгээр булшнууд нь гадаад хэлбэр, зохион байгуулалтын хувьд Түвшинширээ сумын нутагт байх Улаан зуухны дөрвөлжин булшуудтай адил ба 3-6-аар бүлэглэн оршиж зарим бүлэг булшны баруун урд талд нэгээс хоёр эгнээ үргэлжилсэн босоо чулуу босгон булшны зүүн хойд талд булш тус бүрийн толгойн тушаа жижиг, дөрвөлжин тахилгын байгууламжийг дагалдуулсан хэлбэр ч тохиолдож байв.

Мөн уг голын доод хэсгээр цөөн тооны хиргисүүр болон дээрхтэй ижил хэв шинжийн дөрвөлжин хэлбэртэй булшнууд тохиолдох бөгөөд Улаан зууханд тохиолддог шиг том хэмжээний дөрвөлжин дагуул, байгууламжууд олон тоогоор илэрлээ. Гадаад зохион байгуулалтын хувьд Улаан зууханд байх дагуул байгууламжуудтай ижил хэдий ч дөрвөлжин булштай залгаа байдлаар тохиолдохгүй байна.

Гадаад зохион байгуулалтын хувьд төстэй Булгийн эх болон Улаан зуухны дурсгалыг өөр хооронд нь харьцуулан судлах нь ийм төрлийн дурсгалын тархалт, угсаа соёлын хамаадлын талаар шинэ хэрэглэгдэхүүнийг бий болгох ач холбогдолтой тул тэдгээрийг дараагийн жилүүдэд малтан судлах зорилго тавьж байна.

БИЧИГТ УЛААН

N 46° 39' 29.3"

E 111° 48' 94.5" Alt 1169 м

Тогоотын голын баруун талд байх хаданд уйгуржин монгол бичгийн хэд хэдэн дурсгал байдгийг нутгийнхан хэлэлцдэг. Энэ удаа бид Бичигт Улаан хад хэмээх газрын дурсгалыг олж тэмдэглэв. Уг дурсгал нь том боржин хадны зүүн урагш харсан нүүрэн дээр хар бэхээр бичигдсэн байх бөгөөд нийт 9 хэсэг бичээс байв. Энэ хадан дээр дээрх бичээсийн ойролцоо хүн эсвэл шувуу дүрсэлсэн улаан зосон зураг байх ба он цагийн уртад маш бүдэг болсон байлаа.


Дээрх бичээс бүхий хаднаас зүүн урагш нэлээн сондгой байрлах нэгэн хаданд хоёр хэсэг газар янгирын дүрсийг сийлсэн байв. Үүний нэгэн дээр хоёр янгирыг, нөгөө дээр арай томоор нэг янгирыг дүрсэлсэн байлаа. Эдгээр бичээс, хадны зургийн талаар тусгайлан дараагийн дугаарт өгүүлэх болно.

МАЛТЛАГА СУДАЛГАА

СҮХБААТАР АЙМАГ, ТҮВШИНШИРЭЭ СУМ, УЛААН ЗУУХ

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг “Улаан зуух” хэмээх газарт 2008 онд МУИС-н хээрийн судалгааны анги хайгуул судалгаа явуулж, олон үед холбогдох 162 булш байсныг илрүүлэн олж, 3 булш малтан судалж, түүнийхээ зарим үр дүнг тоймлон хэвлүүлсэн билээ (Наваан нар, 2008: 1-36)

Энд орших цогцолбор дурсгалуудын дийлэнх нь Зуухын голын баруун дэвсэгт хойноос урагш цувран байрлах бөгөөд хойд хэсэгтээ үндсэн 3 эгнээ зохион байгуулалттай. 2008 онд энэхүү бүлэг булшны баруун дээд хэсэгт 3 булш малтан судалж сонирхолтой эд өлөг, зан үйлийн зарим элемент илрүүлэн олж байсан. Энэ удаад бид гол эгнээний хойд захад цувран орших 5 булшийг малтан судлав. Эдгээр нь өмнө жилд бүртгэснээр 5-9-р булшууд (Наваан нар, 2008: 1-36) бөгөөд дараас чулуудаараа нийлэн цувран байрлах тул 15х6 метрийн харьцаатайгаар нийт талбайгаар нь цэвэрлэн малтлаа (Зураг 1, Гэрэл зураг 2). Ингэхдээ эдгээр булшуудыг хойноос нь эхлэн А, В, С, D, Е хэмээн тэмдэглэн баримтжуулалтыг үйлдлээ.



Зураг 1. Сүхбаатар аймаг, Түвшинишрээ сум. Улаан зуух. 5-9-р бушины. Чулуун дараас

5-р булш (А).


N 46°39'05.0"

Alt 1074 м

E 111°51'41.6"

Хэмжээ 4 х 3.5 м

Хамгийн хойд захад байрлах том хэмжээтэй булш. Газрын хөрсөн дээр 4х3.5м харьцаатай дөрвөлжин хашлага, түүнийг тойрсон олон тооны хавтгай чулууд харагдаж байв. Зүүн талын хашлага нь бусад талаасаа өндөр байв. 70 см гүнээс



2,25х70 см хэмжээтэй зүүн хойш чиглэсэн толбо илрэн 1 м гүнээс зүүн хойд зүгт хандуулан түрүүлгэ нь харуулан тэнэгэр байдлаар оршуулсан ахимаг настай эрэгтэй хүний оршуулга гарав (Зураг 2, Гэрэл зураг 3). Хүний ясны олдвор маш сайн хадгалагдсан байсан ба толгой, аман хүзүүний яснаас бусад яс бүрэн олдож баруун талын далны яс, эгэм, 1-р хавиргануудаас бусад яс анатомийн байрлалаа хадгалан

үлджээ. Булшнаас ямар нэг эд өлгийн зүйл илэрсэнгүй.

Зураг 2. Сүхбаатар аймаг, Түвшинширээ сум. Улаан зуух. 5-р булш.

Чулуун дараас, хөндлөн зүсэлт, оршуулга

6-р булш (В).

N 4639048

Alt 1072 м

E 11151418

Хэмжээ 2 х 2.4 м

Хойд хашлагын урт 2,4 м, өндөр 40 см, 3 том чулуугаар хийжээ. Зүүн талын хашлага чулуу бусдаас өндөр 74 см байв. Бид булшны зохион байгуулалтыг мэдэхийн тулд эхлээд хашлагын гадна талаар чигжсэн чулууг зайлуулан цэвэрлэгээ хийгээд, үүний дараа хашлагыг авч чулуун өрлөгийг гарган фото зургийг авч баримтжуулав (Гэрэл зураг 4). Булшийг өргөргийн шугамын дагуу зүсэлт хийж үзэхэд хашлага дотор зүүн хэсэгт чулуугүй, баруун хэсэгт дөрвөлжин хүрээний доторх чулуун өрлөг эвдэгдсэн байдалтай байв (Гэрэл зураг 4В). Хашлагын дотор малтлага хийхэд хашлага чулуудын доод ирмэгийн түвшинд буюу 50 см гүнээс жижиг толбо илрэв. Малтлагын явцад богийн хугархай яс илэрсэн ба толбо тодорхой ялгагдахгүй явсаар 90 см гүнд бага насны хүүхдийн яс эмх замбараагүй байдлаар илэрлээ. Уг булшинд дагалдуулсан эд өлгийн зүйл байсангүй. Зүүн талын

дал болон бугалга яс анхны байрнаасаа хөдлөөгүй байснаас үзвэл хүүхдийг зүүн хойд зүг хандуулан түрүүлгэ нь харуулан оршуулсан байв.

7-р булш (C).


N 4639048

Alt 1074 м

E 11151421

Хэмжээ 3 х 3 м

Зохион байгуулалтын хувьд Булш – В-тэй адил бөгөөд хэмжээний хувьд ялимгүй том. Хашлагын дээд хэсгээс 1 ш адууны шүд илэрсэн. Хашлагын дотор 70 см малтахад зүүн хойш чиглэсэн битүү чулуун дараас илрэв. Уг дараасын урт 160 см, өргөн 70 см. Түүний доороос хүүхдийн эрүү, хавирга, хүзүүний нугалам, богтос, адууны шүд зэрэг яс эмх замбараагүй байдалтай илрэв. 75 см гүнээс 7-8 орчим насны хүүхдийн баруун талын бугалга, шуу, дунд чөмөг, шилбэ, далны яс, зүүн талын бугалга, дунд чөмөгний яснууд анатомийн байрлалаараа олдсон ба зүүн хойд зүг хандуулан түрүүлгэ нь харуулан оршуулжээ. Дагалдуулсан эд өлгийн зүйл үгүй (Зураг 3, Гэрэл зураг 5).



Зураг 3. Сүхбаатар аймаг, Түвшинширээ сум. Улаан зуух. 7-р булш . Чулуун дараас, хөндлөн зүсэлт, оршуулга

8-р булш (D).

N 4639045

Alt 1074 м

E 11151416

Хэмжээ 1,9 х 2 м

6 том хавтгай чулуудаар дан үе дөрвөлжлөн өрж үйлдсэн чулуун байгууламж бөгөөд хашлагын дотор малтахад 60 см гүнээс бага насны хүүхдийн яс эмх замбараагүй байдалтай илэрсэн болно (Гэрэл зураг 6А).

9-р булш (E).

N 4639045

Alt 1074 м

E 11151423

Хэмжээ 5 х 5 м

Хамгийн урд захад орших ба бусад булшнуудын дагуул байгууламж бололтой. Хөрсөн дээр 2 үе хавтгай чулуудыг өрсөн ба түүнийг тойрон олон чулууд тархсан байдалтай. 20 см гүнд бод, бог малын яс илэрсэн бөгөөд өөр ямар нэг оршуулга, эд өлгийн зүйл илэрсэнгүй. Энэхүү булш нь тахилгын зориулалтаар үйлдсэн байгууламж бололтой (Гэрэл зураг 6Б).

Чулуун байгууламж

N 46° 39' 04.6"

E 111°51' 45.9" Alt 1064 м


Энд орших булшнууд дунд хавтгай чулуудыг газарт цувруулан зоож үйлдсэн том чулуун байгууламжууд цөөн тоогоор тохиолддог. Бидний тоолсноор 3 ийм байгууламж байх ба гол төлөв том хэмжээний булшны зүүн талд, залгаа үргэлжилсэн байдалтай тохиолдож байна. Тэгш дөрвөлжин хэлбэртэйгээс гадна булштай залгаа цагариг хэлбэртэй ч тааралдаж байв.

Эдгээрээс хэмжээний хувьд хамгийн томыг нь сонгон зохион байгуулалтыг тодруулах үүднээс сорилтын малтлага явуулав. Энэ нь Улаан зуухын оршуулгын талбайн зүүн хэсэгт сондгой орших том хэмжээний дөрвөлжин булшны зүүн урд талд оршино. Нийт талбай 10х11 м хэмжээтэй, тэгш өнцөгт хэлбэртэй, цуварсан хоёр том байгууламжийн зүүн талд 4 өнцөгтөө босоо чулуутай, босоо чулуудын хооронд нимгэн хавтгай чулуудыг газарт шигтгэн зоож хийсэн байгууламж болно. Байгууламжийн өнгөн хөрсийг цэвэрлэж үзэхэд хойд тал 8,6 м, баруун тал 10,3 м, урд тал 7,8 м, зүүн тал 9,9 м хэмжээтэй байв. Мөн байгууламжийн баруун хойд өнцөг орчмоор чулуугүй бөгөөд зүүн хойд өнцөгт 90х100 см, хойд талын голд 150х290 см, баруун хойд өнцөгт 100х85 см, зүүн талын голд 195х100 см хэмжээтэй чулуун хайрцаг хийсэн байв. Малтлагын явцад баруун хойд талын хашлагаас богийн яс илэрсэн болно. Байгууламжийн дотор талд урдаас хойш чиглүүлэн түүний төв хүртэл хоорондоо 210 см зайтай хоёр эгнээ чулуудыг, чулуу хооронд 50 см зайтайгаар цувруулан өржээ. Байгууламжийн дунд, мөн хойд талын чулуун хайрцагнаас урагш 250 см зайд 2 хавтгай чулууг хөндөлдүүлэн зоосон байв (Зураг 4, Гэрэл зураг 7).

Өөр зан үйлийн холбогдолтой ул мөр илрээгүй ба дээрх том дөрвөлжин булштай холбоотой тахилгын зориулалтаар үйлдсэн байгууламж бололтой. Энэхүү байгууламжтай гадаад зохион байгуулалтын хувьд ижил төстэй хэв шинжийн байгууламжууд Улаан зуухаас баруун зүгт орших Булгийн эх хэмээх газарт олноор тохиолдсон ба одоогоор тэнд малтлага судалгаа хийгдээгүй байна.

Булшны гадаад зохион байгуулалт: Энэхүү сонгон авсан булшнууд нь энд тохиолдох хамгийн том ба жижиг хэмжээний булшуудыг хамруулснаараа онцлогтой. Уг булшнууд тэгш дөрвөлжин хэлбэртэй, ерөнхий чиглэл нь азимутын

340° хэмд баруун хойш хазайсан, баруун хойноос зүүн урагш чиглэлтэй цувран байрласан байлаа. Булшнуудыг үйлдэхдээ дунджаар 30х20х10 см хэмжээтэй



Зураг 4. Сүхбаатар аймаг, Түвшинширээ сум. Улаан зуухад орших чулуун байгууламж

хавтгай чулуугаар дөрвөлжин хүрээ гарган 5-6 үе давхарлан өрж төв хэсгийг жижиг чулуудаар битүү чигжжээ. Дөрвөлжин хүрээг маш тодорхой гаргасан байх ба ингэхдээ хавтгай чулуудыг булангаас эхлэн өрж дараагийн чулуугаар ирмэгийг даруулан хөдөлгөөнгүй болгосон байх бөгөөд гол дунд нь нэг чулуугаар хоёр талын чулууг даруулан тавьсан харагдаж байв (Гэрэл зураг 3, 8). Өрлөгийн гадна талаар ойр орчмын боржин хаднаас цуулан авчирсан хавтгай чулуудыг ирмэгээр нь босгон тулган тавьж хашлагыг үйлджээ. Ингэхдээ зүүн болон хойд талын хашлага бусдаас өндөр бөгөөд иймэрхүү бүтэц, зан үйл энд байх ихэнх булшинд тохиолдох

түгээмэл хэлбэр болно. Зарим тохиолдолд зүүн хойд буланд хөшөө чулуу босгожээ. Ихэнх булшны гадаад зохион байгуулалт нэлээд эвдэрсэн байв. Булшнуудыг үйлдсэн зохион байгуулалтыг харахад хүнээ хөдөөлүүлэхдээ оршуулгын нүхээ ухаж хүнээ булаад, нүхийг тойруулан хавтгай чулуудыг давхарлан өрж дөрвөлжин хүрээ хийсэн байх ба оршуулгын нүх болон чулуун хүрээн доторх зайг чулуудаар битүү чигжин дүүргэжээ. Дөрвөлжин өрлөгийн гадна талаар том хавтгай чулуудыг түшүүлэн босгож хашлага хийгээд хормойгоор нь жижиг хавтгай чулуудаар чигжин хөдөлгөөнгүй болгон даруулсан ерөнхий зохион байгуулалт харагдаж байлаа.

Дөрвөлжин булшийг дагнан судалсан эрдэмтэд ийм хэлбэрийн булш нь хашлага болон булангийн чулуу, дараасын хэлбэр хэмжээгээрээ харилцан адилгүй олон төрөл байдгийг тэмдэглэн доорх байдлаар ангилсан байдаг. Үүнд: 1920-иод онд Г.П.Сосновский:

1. Өндөр чулуун хашлагатай бөгөөд 4 буландаа гозгор чулуутай
2. Намхан дөрвөлжин чулуун хашлага, түүний гадуур хавтгай чулуун дараасаар хүрээлсэн
3. Талууд нь дотогш хотойсон хавтгай чулуун дараастай хэмээн 3 ангилаад эхний хэлбэр нь МЭӨ VI-III зуун, хоёр дахь хэлбэр нь МЭӨ III-II зуунд хамаарна гэж үзсэн ба (Сосновский 1941: 307-308) хожим 1.5 м хүртэл өндөр хашлага чулуу бүхий 4-р хэлбэр байна гэж үзжээ.

Ц.Төрбат Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Эрдэнэхайрхан ууланд малтсан 2 булшны хэрэглэгдэхүүнийг урьд өмнө малтан судлагдсан дөрвөлжин булшны гадаад, дотоод зохион байгуулалт, зан үйлтэй харьцуулан үзээд Дөрвөлжин булшны соёл нь он цагийн хувьд ялгаатай 2 үед хуваагдана хэмээн үзжээ (Төрбат 2004: 5-9). Тэрээр дээрх Г.П.Сосновскийн дөрвөлжин булшны гадаад зохион байгуулалтын ангиллын 1-р төрлийг “Хэрлэнгийн төрлийн булш”, 2-р төрлийг “Туул”-ын хэлбэрийн булштай дүйнэ хэмээгээд он цагийн хувьд МЭӨ XIII-VIII, МЭӨ VIII-IV зуунд холбогдуулах санал гаргажээ. Эцэст нь тэрээр дөрвөлжин булшны гадаад хэлбэр төрх өндөр чулуун хашлагатай, 4 буландаа гозгор чулуутайгаас намхан дөрвөлжин хашлага, түүний гадуур хавтгай чулуун дараастай болж хөгжсөн (Төрбат 2002: 9) хэмээн тодорхойлжээ.

Бидний судалгаа явуулсан Улаан зууханд дээрх ангилалд дурдсан, гадаад зохион байгуулалтын хувьд “Намхан дөрвөлжин чулуун хашлага, түүний гадуур хавтгай чулуун дараасаар хүрээлсэн” булш зонхилох агаад 4 буландаа өндөр босоо чулуудтай булш ч бас тохиолдож байв. Гэвч эдгээр булшнуудын оршуулгын зан үйл бусад дөрвөлжин булшнуудаас ялгаатай өвөрмөц байсан нь уг дурсгалыг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатайг харуулж байна.

Оршуулгын зан үйл. Энд малтан судалсан булшнуудад хүнээ гүн бус нүхэнд толгойг нь зүүн хойд зүг чиглүүлэн, тэнэгэр байдалтай түрүүлгэ нь харуулан оршуулдаг зан үйд ажиглагдлаа. Ингэхдээ хойлго, тахилга, эд өлгийн зүйл дагалдуулдаггүй ба хүүхэд болон насанд хүрсэн хүний оршуулгын хооронд тодорхой зан үйлийн ялгаа ажиглагдсангүй. 2009 онд малтсан хойноос урагш цуварсан 5 дөрвөлжин булшны хамгийн хойд захын 5-р булшнаас насанд хүрсэн эрэгтэй хүн, 6-р булшнаас 5-6 орчим насны хүүхэд, 7-р булшнаас 7-8 орчим насны хүүхэд, 8-р булшнаас 5 орчим насны хүүхдийн оршуулга илэрсэн ба хамгийн сүүлийн байгууламж нь дээрх оршуулгуудад дагалдуулсан тахилгын зориулалттай байгууламж бололтой.

Дээрх булшнуудад харагдах өвөрмөц нэгэн хэлбэр бол түрүүлгэ нь харуулан оршуулах зан үйл болно. Улаан зуухын оршуулгын газарт 2 жил дараалан нийт 7 булш малтсаны 6-аас нь оршуулгын ул мөр илэрсэн бөгөөд үүнээс нас барагчийн байрлал мэдэгдэж байсан 5 булш бүгд түрүүлгэ харуулсан оршуулгатай байлаа.

2008 онд энд малтсан 42-р булшийг эс тооцвол бусад булшууд гадаад зохион байгуулалтын хувьд адил дөрвөлжин хэлбэртэй бөгөөд өөр хоорондоо нийлэн оршино. Улаан зуухын 42-р булш нь гадаад зохион байгуултын хувьд дугуй хэлбэртэй байсан ба нас барагчаа газрын уруу хандуулан зүүн хойш чиглүүлэн, тэнэгэр байдлаар түрүүлгэ нь харуулан оршуулаад чулуун эдлэл дагалдуулсан байжээ (Наваан нар, 2008: 1-36).

Сүүлийн жилүүдэд манай улсад гадны олон улстай хамтран археологийн судалгааг өргөн явуулах болсноор урьд өмнө төдийлөн судлагдаж байгаагүй археологи, угсаатны шинэ хэрэглэгдэхүүнийг олноор илрүүлж байна. Тэдгээрийн нэг болох Монгол нутаг дахь хүрэл зэвсгийн үеийн археологийн дурсгалуудад нас барагчаа түрүүлгэ нь харуулан оршуулсан тохиолдол сүүлийн жилүүдэд цөөнгүй илэрсээр байна. Хүнийг түрүүлгээ харуулан оршоосон оршуулга Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уулнаа малтсан 5 хэлбэрт булшнаас (Новгородова 1989), мөн уулын баруун урд орших Хад үзүүрт малтсан шоргоолжин болон “Дөрөө” хэлбэрийн булшнаас, Баянхонгор аймгийн Баянлиг сумын Баруун Гялаатад малтсан 1 шоргоолжин булш болон замын бууц 1-р булшнаас (Эрдэнэбаатар нар 2009:12), Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Умдаан голын хэлбэрт булшнаас (Цэвээндорж 2005а), Өмнөговь аймгийн Номгон сумын Цагаан толгойд малтсан шоргоолжин булшнаас (Түмэн нар., 2008:19), Өмнөговь аймгийн Ухаа худагт малтсан дугуй чулуун дараастай булш (Амартүвшин 2008: 213-234), Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Чандмань хар уулнаа малтсан дөрвөлжин чулуун хашлагатай 8 булшинд (Амартүвшин нар 2007: 141), Говь алтай аймгийн Улаанбоомын хавцалд (Цэвээндорж 2005а), Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын

Бага газрын чулууны Бага Монголын 1-р хэлбэрт булш, Дунд шандын 1-р булшнаас (Амартүвшин 2008: 77-91) тус тус илрээд байна.

Эдгээрийг нэгтгэн үзвэл түрүүлгэ нь харуулан оршуулсан булш Манай улсын Өвөрхангай (7), Өмнөговь (2), Дорноговь (8), Баянхонгор (2), Сүхбаатар (7)1, Говь-Алтай (1), Дундговь (2) аймгуудын нутгаас олдсоныг судлаачид хэвлэн нийтлүүлсэн 28 тохиолдол байна. Эдгээрээс дийлэнх нь шоргоолжин (Хэлбэрт) булш болох бөгөөд дөрвөлжин булш 3, дугуй дараастай, дөрвөлжин хашлагатай 8, дугуй хэлбэрийн 4, дөрөө хэлбэрийн 1 булш бүртгэгджээ.

Ийм төрлийн оршуулгын зан үйлийг тусгайлан судалсан судлаачид цөөн бөгөөд энэ нь түрүүлгэ харуулан оршуулах оршуулга олноор олноогүй байсантай холбоотой бололтой.

Археологич Ч.Амартүвшин, Ч.Ерөөл-Эрдэнэ, Б.Гүнчинсүрэн, Б.Цогтбаатар нар Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын нутаг Чандмань Хар уулнаа хүнээ түрүүлгэ нь харуулан оршуулсан дугуй хэлбэртэй дөрвөлжин хашлагатай 8 булш малтан судалсан ба түүнийхээ хэрэглэгдэхүүнийг Монгол, Өвөр Байгальд малтан судалсан хүнээ түрүүлгэ нь харуулсан оршуулгуудтай харьцуулан, холбогдох угсаатны зүйн мэдээ баримтуудыг дурьдан ёс бусаар буюу онцгой тохиолдлоор нас барсан хүнийг оршуулах хэлбэр байжээ хэмээн үзсэн байна (Амартүвшин нар, 2007: 141). Тэдгээр булшуудыг судлаачид хүрлийн эхэн үе, магадгүй, Энеолитийн үед холбогдох бололтой хэмээжээ. Мөн тэд БНХАУ-н Цзянсу мужийн Юйдуны неолитийн соёл Ючинь Цинльньчаны 25 булшны 23-т нь ийм зан үйл байдаг тухай дурьдсан байна.

Археологич Д.Эрдэнэбаатар “Тэвшийн соёл” хэмээх нэр томъёог гарган тавьж, дотор нь шоргоолжин болон “дөрөө” хэлбэрийн оршуулгын байгууламжийг багтаагаад ...“дөрөө” хэлбэрийн булш гэж нэрлэж байгаа булшны оршуулгын зан үйл, “шоргоолжин” хэлбэрийн булшинд хүнээ түрүүлгэ нь харуулж тавьсан байгаатай ижил зан үйлтэй учраас уг дурсгал “Тэвшийн соёл”-д хамаарна гэдгийн давхар баталгаа болно”... хэмээн үзээд түрүүлгэ нь харуулан оршуулах зан үйл нь “дөрөө” болон шоргоолжин булшийг нэгэн соёлын хүрээнд багтаан үзэх нэгэн үндэслэл хэмээн үзжээ (Эрдэнэбаатар нар, 2009: 12).

Гэхдээ бидний дурьдан буй булшууд нь гадаад хэлбэрийн хувьд шоргоолжин (хэлбэрт) булш болон “дөрөө” хэлбэрийн булштай адилгүй бөгөөд дотоод зан үйлийн хувьд хүнээ түрүүлгэ нь харуулан оршуулсан байдгаараа л ижилсэж байна.

¹ Энэ нь МУИС-ийн “Дорнод Монгол” төслийн хүрээнд Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутагт 2008, 2009 онуудад малтсан 7 булш болно.

Түрүүлгэ нь харуулан оршуулах нь шоргоолжин (хэлбэрт) булшны гол онцлог зан үйл гэдгийг судлаачид удаа дараалан тэмдэглэсээр ирсэн хэдий ч дөрвөлжин булшинд тохиолдсон нь тэмдэглэгдээгүй ажээ. Үүнээс гадна ийм зан үйл бүхий булшнууд нь хамрах бүс нутаг, он цагийн хувьд ойролцоо байгаа нь дөрвөлжин болон шоргоолжин (хэлбэрт) булшны соёлт хүн амын угсаа гарвал, соёл, харилцан хамаадлын талаар өгүүлэх нэн чухал баримт болох боломжтой. Дөрвөлжин болон шоргоолжин булшийг судалсан судлаачид зарим нь дээрх соёлуудыг нэгэн хүрээнд (Боровка 1927:61-62; Волков 1967; Диков 1958:108; Киселев 1947:371; Сосновский 1928) авч үздэг бол зарим нь дөрвөлжин булшны соёлыг үлдээгчдээс ялгаатай (Гришин 1980: 12-15; Криллов, Окладников и др., 1980; Эрдэнэбаатар нар, 2008; 6-8) хэмээн үздэг ажээ.

Гэтэл археологич А.Д.Цыбиктаров “шоргоолжин булш”-ны соёлыг үлдээгчдийг, одоо хуримтлагдсан судалгааны эх хэрэглэгдэхүүнээр бие даасан соёл мөн үү? биш үү? гэдгийг шүүн хэлэлцэх хангалттай эх сурвалж алга (Цыбиктаров 1998: 126-128) хэмээн үзэж байна.

Эдгээрээс харвал Улаан зуухын дөрвөлжин булшнууд нь шоргоолжин (хэлбэрт), дөрөө хэлбэрийн булшны соёлтой оршуулгын дотоод зан үйлийн хувьд ижил хэдий ч гадаад зохион байгуулалтын хувьд дөрвөлжин булшны соёлтой холбогдож, дээрх соёлуудыг нэгэн соёл, он цагийн хүрээнд авч үзэх шижим болох боломжтой чухал дурсгалт газар болж байгаа бөгөөд цаашид хийгдэх малтлага, судалгаа энэ асуудалд тодорхой хариулт өгч болохыг судалгааны урьдчилсан үр дүн харуулж байна. Иймээс дараа дараачийн жилүүдэд энэ дурсгалт газар малтлага судалгааг улам өргөн зохион явуулж уг дурсгалыг гүнзгийрүүлэн судлах, чулуун байгууламж болон булшны цогцолборыг хамтад нь малтан судлах зайлшгүй шаардлага гарч байна.


СҮХБААТАР АЙМАГ, ТҮВШИНШИРЭЭ СУМ, ИХ ХӨМӨГ

1-р булш.

N 46° 37' 50.6”

Хэмжээ 3.7x1.2 м

E 111° 48' 11.0”



Зураг 5. Сүхбаатар аймаг, Түвшинширээ сум. Их хөмөг. 1-р булш. Чулуун дараас

Уг булш нь Түвшинширээ сумын нутаг дах Дэлгэрхаан уулын Их хөмөгийн амны дээд мухарт байрлах ба цувраа боржин хаднуудын завсар 2 талд нь 4 хавтгай чулуу босгон хашлага хийж, түүн дотроо урт хавтгай чулуудаар дараас үйлдэн хийжээ. Ийм төрлийн байгууламж ойр орчимд нэлээн тохиолдоно. Хашлагын дотор малтахад хавтгай чулуудыг зохион байгуулалттайгаар өрж хийсэн байх хэдий ч 1 метрийн гүнд хүрэхэд байгалийн боржин хад тулан малтлага зогсов. Ямар нэгэн антропологи, археологийн материал илэрсэнгүй (Зураг 5, Гэрэл зураг 9).

СҮХБААТАР АЙМГИЙН МӨНХХААН СУМЫН НУТАГТ ЯВУУЛСАН АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА

ХАЙГУУЛ СУДАЛГАА

ХУУРАЙ БУРГАСТАЙ, БАРГА ЭЛС.

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг Ачаат уул, Устай бургастайн Барга элс зэрэг монголын түүхийн палеолит, неолитийн дурсгалт газруудад хайгуул хийж ховор нандин олдворуудыг түүвэрлэн цуглуулав. Түвшинширээ сум, Мөнххаан сумын нутгаас олдож буй неолитийн үед хамаарах төрөл бүрийн олдворуудыг харахад уг бүс нутагт неолит, хүрлийн түрүү үед түүвэрлэх аж ахуй бүхий анчин загасчин отог омгууд нүүдэллэн амьдарч байжээ.

МАЛТЛАГА СУДАЛГАА

ХУУРАЙ БУРГАСТАЙ, БАРГА ЭЛС, ШИНЭ ЧУЛУУН ЗЭВСГИЙН БУУЦ.

N 46° 55' 20.3"

E 112° 12' 44.9"

Хуурай бургастайн орчим хайгуул хийхийн зэрэгцээ Барга элснээс неолит зэвсэг олноор олддог тул уг манханд соёлын давхарга байгаа эсэх, түүний он цаг, соёлын хамаадлыг тандахаар туршилтын малтлага хийв (Гэрэл зураг 10). Малтлагын дүнгээс харахад уг манханд неолитийн үеийн түүвэрлэгч, анчин отог омгуудын түр зуурын сууц байсан бололтой бөгөөд байгалийн салхи, ус, агаарын нөлөөгөөр бүрэн устаж үгүй болсон бололтой. Уг дурсгалт газраас олдож буй неолитийн үеийн чулуун зэвсэг, үлдцийн хийц технологи Байгал орчмын неолит зэвсэгтэй төстэй, тухайлбал, Барга элснээс олдсон ваар Мухан нуурын суурингаас олддог ваартай адил байгаа нь неолитийн түрүү үеэс хүрлийн түрүү үеийг хүртэл Дорнод Монголын болон Байгалын чанад нутагт нэгдмэл соёл бүхий, магадгүй угсаа гарвалын хувьд ч нэгдмэл овог аймгууд оршин сууж байсан тухай судлаачдын таамаглалыг бататгаж байна (Дорж, 1971). Энэ тухай хожим дэлгэрэнгүй бичих тул энд товч өгүүлэв.



Барга элс 1-р булш.

N 46° 54' 53,9”

Alt 1254 м

E 112° 12' 41,2”

Хэмжээ 5 х 5 м

Барга элсний чанх урд орших уулын хойш унжсан хамар дээр байрлах булш. Зүүн талдаа том хөшөө чулуутай. 50 см гүн малтахад богийн чөмөгний яс илэрснээс өөр зүйлгүй. Тахилгын зориулалтаар үйлдсэн байгууламж бололтой (Зураг 6, Гэрэл зураг 11).

Зураг 6. Сүхбаатар аймаг, Мөнххаан сум, Барга элс. 1-р булины чулуун дараас

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯН-ОВОО СУМЫН НУТАГ МАЙХАНТ ТОЛГОЙД
ЯВУУЛСАН АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА**

ХАЙГУУЛ СУДАЛГАА

Хэнтий аймгийн Баян-Овоо сумын төвөөс чанх урагш 5 км-т Хэрлэн голын урд эрэгт орших Майхант толгойн хойд доор орших элсэн мөргөцөгт неолитийн үед холбогдох чулуун зэвсэг, үлдцүүд олддог гэх мэдээний дагуу хайгуул болон малтлага судалгааг явуулав. Энд хойноос урагш үргэлжлэх 3 том элсэн мөргөцөг байх ба олон үед холбогдох ваарны хагархай, хуучин болон шинэ чулуун зэвсгийн үед холбогдох залтас, ялтас зэвсгүүд илэрч байв. (Гэрэл зураг 12) Үүний зэрэгцээ энэ мөргөцөг дэх бууц газруудад олз хайсан хүмүүс удаа дараагаар ирж, энд тэндгүй онгичин ухсан ул мөр газар сайгүй тааралдаж байв.

МАЛТЛАГА СУДАЛГАА

Элсэн мөргөцөгт хайгуул хийж байх явцад тэдгээрийн голын мөргөцөгөөс эрт үед холбогдох нэгэн оршуулга санамсаргүй байдлаар илрүүлж, малтан судаллаа.

1-р булш.


N 47° 44' 44.3”

E 112° 06' 42.0”

Alt 945 м

Төв мөргөцөгт хайгуул судалгааг хийх явцад манхны элсэн давхарга дундаас үл ялиг хар толбо цухуйсан байсныг шалгаж үзэхэд хүний хөлийн яс илэрч улмаар үргэлжлүүлэн малтахад хар өнгийн судал 2 х 0.6 м хэмжээтэй, зүүн хойд зүг чиглэсэн толбо болон үргэлжлэв.

Тус мөргөцөг нийт зургаан үетэй мэт мэдэгдэж байгаагийн тавдугаар үед буюу эргийн ирмэгээс доош 2.1 м гүнд орших энэхүү оршуулга хөрсний нурултаас ийнхүү ил гарч ирсэн бололтой. Энэ гүнээс зүүн хойд зүг чиглэсэн анатомийн байрлалаа хадгалан үлдсэн эрэгтэй хүний оршуулга илэрсэн бөгөөд хавирга болон



сээрний нугалмууд үрэгдэн алга болсон байлаа (Зураг 7, Гэрэл зураг 13). Хүнийхээ нүүрийг зүүн зүг харуулан тавьсан байх ба зүүн мөрний дээд талд ногоон өнгийн чулуун сувс, даавуунд ороосон 2 ш хүрэл зэвийг дагалдуулан тавьсан байв. Ууцнаас дээш 3 үе нурууны орчим 2 ш цагариг төмөр эдлэл, зүүн ташааны орчим хавтгай төмөр эдлэл, баруун гарын сарвууны орчмоос мөн жижиг төмөр эдлэлийн үлдэгдэл тус тус илэрлээ (Зураг 8, Гэрэл зураг 14). Нойтон элсэнд төмөр эдлэлүүд маш муу хадгалагдсан учир тэдгээрийн зориулалтыг тодорхойлох боломж хомс байв.

Зураг 7. Хэнтий аймаг, Баян-Овоо сум, Майхант уул. 1-р бушины оршуулга



Олдворын тодорхойлолт

3 хянгат хүрэл зэв. 2 ш. Сурвалжгүй, онгит зэв, урт 3.2 см, суурийн өргөн 1.2 см.

Ногоон өнгийн чулуун сувс. 1ш. Диаметр 0.6 см

Зураг 8. Хэнтий аймаг, Баян-Овоо сум, Майхант уул. 1-р бушинаас олдсон хүрэл зэв

ДОРНОД АЙМАГ, БУЛГАН СУМАНД ЯВУУЛСАН АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА

ХАЙГУУЛ СУДАЛГАА

Норовлин уул

N 48° 02' 41.8"

E 113° 45' 13.7" Alt 798 м.

Дорнод аймгийн Булган сумын Норовлин уул нь неолитийн бууц олдсоноороо монголын археологит чухал дурсгалт газарт тооцогддог. Бид энэ удаа Норовлин уулын Хэрлэн гол руу түрж орсон зүүн хойд, хойд хормой бэл болон баруун суга, түүний дагуу байх гүн жалгын дагуу хайгуул хийлээ. Неолитийн үеийн зэвсэг, үлдэц, залтас хэсгүүд энд нэлээн олдож байсан ба зарим газар илүү бөөн олноор олдож байв. Ийм олноор олдсон газрын нэгний координатыг өгөв.

Булган сумын нутаг дах өөр нэг дурсгал бол Тугийн сүмийн туурь юм. Уг туурь Хэрлэн голын урд талд жижгэвтэр толгойн орой дээр байх ажээ. Дорнод

аймгийн соёлын өвийн ажилтан Мангалжавын Тугийн сүмийн ойр орчимд неолит зэвсэг ихээр олддог тухай бидэнд мэдээлсний дагуу бид уг газар неолитийн үеийн бууц суурин, дархны газар байж болох эсэхийг шалгахаар хайгуул хийлээ. Хайгуулаар Тугийн сүмийн толгойн арын хөндийгөөс неолитийн үеийн үлдэц, ялтас, залтас, үлдэц ихээр олдсон бөгөөд ихэвчлэн саарал өнгийн цахиурлаг чулуугаар үйлдсэн чулуу боловсруулалтын анхдагч шатны залтаснууд байгаа нь уг газар неолитийн үеийн дархны газар байсныг харуулж байна. Цаашид энэ газар нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай гэж үзлээ.


МАЛТЛАГА СУДАЛГАА

Соёлын өвийн төвийн мэргэжилтэн Б.Даваацэрэнгийн Дорнод аймгийн Булган сумын төвөөс баруун хойш 4 орчим км-т орших Холбоо толгой хэмээх газарт хэд хэдэн булш устах аюулд ойрхон болсон байгаа тухай мэдээлснээр бид уг газар очиж ажилласан бөгөөд хөрсний эвдрэлээр сүйтгэгдэх дөхсөн 3 булш малтан судлав.

Холбоо толгой. 1-р булш .

N 48° 00' 52,8”

E 113°53' 22,4” Alt 792 м




Булган сумаас баруун хойш Хэрлэн голын хойд дэнжид байх намхавтар холбоо толгойн энгэрт байрлах том чулуудаар үйлдсэн дугуй хэлбэртэй булш. Дараас чулуудын зохион байгуулалт хөндөгдсөн гэх шинж үгүй. Цэвэрлэгээний явцад ширмэн тогооны хагархай, нимгэн төмөр ялтсууд, хар болон хүрэн өнгийн ваар савны хагархайнууд олноороо илэрч байсан бөгөөд 60 см гүнээс шинэ чулуун зэвсгийн үлдэц, хар өнгийн ваарны хагархай гарав. Малтлагын гүн 110 см хүрэхэд оршуулга илэрсэнгүй, байгалийн хөрс тулав (Зураг 9, Гэрэл зураг 15).

Зураг 9. Дорнод аймаг, Булган сум, Холбоо толгой, 1-р булшны чулуун дараас

Холбоо толгой. 2-р булш .

N 48° 00' 52,5”

E 113°53' 32,3” Alt 784 м



Зураг 10. Дорнод аймаг, Булган сум, Холбоо хоёр, 2-р булины хашлага чулуу, ваар

Хэрлэн голын хойд эргийн дагуух элсэн мөргөцөгт байрлах бөгөөд булшны гадна талын дараас чулууд уруйн усанд урсан эвдэгдсэн бололтой хөрсөн дээр цөөвтөр тооны тодорхой зохион байгуулалтгүй чулууд үлдсэн байв. Малтан судлахад 30 см гүнээс 1 м урт 50 см өргөн жижиг чулуун хашлага илэрсэн бөгөөд түүнд хойд зүгт хандуулан тавьсан бага насны хүүхдийн гавлын яс, төмөр зэв, улаан лакан эдлэлийн хэсэг, толгойн баруун хэсэгт хар өнгийн бүтэн шавар ваар зэрэг зүйлс илэрлээ (Зураг 10, Гэрэл зураг 16).

Холбоо толгой. 3-р булш.

N 48° 00' 52,5"

E 113° 53' 32,3" Alt 784 м

Холбоо толгойн зүүн урд, гол руу түрэн орсон мөргөцгийн элсэнд тодорхой зохион байгуулалтгүй цөөн тооны чулууд байсныг малтан үзэхэд 80х50 см хэмжээтэй жижиг чулуун хашлага илрэв. Малтлагын гүн 1,1 м хүрэхэд хашлагын хойд хэсэгт хүүхдийн маш муу хадгалагдсан гавлын яс, түүний зүүн талд улаан лакан эдлэлийн үлдэгдэл, хүзүү орчим 2 ш хуван болон чулуун зүүлт, толгойн баруун талд хонины толгой тус тус олдов. Оршуулгыг анх үйлдэхдээ чулуун хашлага хийж, банзаар таглаа хийсэн нь маш муу хадгалагдан үлджээ. Дээрх булшнууд он цагийн хувьд Хүннүгийн үед холбогдох бололтой (Гэрэл зураг 17).

**ДОРНОД АЙМГИЙН ГУРВАНЗАГАЛ СУМЫН НУТАГТ ЯВУУЛСАН
АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА**

ХАЙГУУЛ СУДАЛГАА

ДОРНОД АЙМАГ, ГУРВАНЗАГАЛ СУМ, ХӨЦӨӨГИЙН ДУРСГАЛУУД

N 48° 59' 22.9”

E 114° 18' 59.6” 853 м

Гурванзагал сумын төвөөс баруун тийш 40 километрт Хөцөөгийн голын гольдролын баруун дэнж дээр байх нэгэн том дөрвөлжин булшны зүүн өмнө этгээдэд хоёр хүн чулуу хойноос урагш цувран орших ба тэдгээрийн дэргэд зураг бүхий жижиг хад газраас цухуйх ажээ. Эдгээр хүн чулууд хийгээд дөрвөлжин булшны талаар археологич Н.Сэр-Оджав Дорнод аймгийн нутгаар хайгуул судалгаа хийх үедээ үзэж товч мэдээлсэн байдаг (2003: 62).

Бид эдгээр хүн чулууд болон түүний хажууд байгаа дөрвөлжин булш, хадны зураг зэргийн нарийвчилсан тодорхойлолтыг хийж, солбицлыг тэмдэглэн, гар болон гэрэл зургийг авлаа. Хойд талынхыг 1, урд талынхыг 2 хэмээн болзолт байдлаар дугаарласан болно.

Нэгдүгээр хүн чулуу. Хавтгай чулууг хөндлөн зоож, оройг мөлийлгөн баруун тийш харсан тал дээр дээд хэсэгт хүний хөмсөг, нүд, хамар, ам, эрүүг товойлгон дүрсэлсэн нь тодорхой харагдана. Хүн чулууны өндөр 70 см, өргөн дээд хэсэгтээ 52 см, ёроол хэсэгтээ 49 см, баруун дээд талдаа 27 см эмтэрсэн, чулууны зузаан хойд хэсэгтээ 12 см, урд тал нь нимгэн 6 см, оройн хэсгийн зузаан 9 см (Зураг 11, Гэрэл зураг 18А).



Зураг 11. Дорнод аймаг, Гурванзагал сум. Хөцөө. А. 1-р хүн чулуу, Б. 2-р хүн чулуу (Баруун талаас)

Хоёрдугаар хүн чулуу. Эхний хүн чулуунаас зүүн урагш 1,6 м зайд оршино. Мөн оройг мөлгийлгөн баруун тийш харсан тал дээр дээд хэсэгт хүний нүүрийг дүрсэлсэн нь маш бүдэг харагдана. Энэхүү хүн чулуу нь 58 см өндөр, 46 см өргөнтэй, 21 см зузаантай. Нүүрний доод хэсэгт зууван дугуй дүрсийг цохиж гаргасан байх ба дээрээс нь давхарлан оройгоор нь доош харуулсан гурвалжин дүрсийг сийлжээ. Чулууны нөгөө талд өнцгөөр нь босгон дүрсэлсэн дөрвөлжин дотор дугуй дүрс, түүнээс доош шулуун татсан байх ба энэ шулуун дээр хөндлөнгөөр таван богино зураасыг гаргасан байв (Зураг 12, Гэрэл зураг 18Б, В, Г).

Сүүлийн жилүүдэд Дорнод аймгийн нутагт явуулсан хайгуул, бүртгэлийн явцад эдгээр хүн чулуутай төстэй хөшөө чулуу Дашбалбар сумын Төмөртэй толгой, Цагаан овоо сумын хөшөө толгой, Чулуун хороот сумын Үхэрт зэрэг газраас олдсон баримт бий (Энхбат, Даваацэрэн 2009:60, 88, 95). Эдгээр хөшөөд нь мөн Хөцөөгийн хөшөөдийн адил дөрвөлжин булшны зүүн талд орших бөгөөд мөнхүү тамга тэмдэг сийлсэн байна. Харин Хөцөөгийн хүн чулууд нь хүний нүүрийг өвөрмөц байдлаар дүрслэн гаргаснаараа дээрх хөшөөдөөс онцлог юм.

Археологич Х.Пэрлээ өмнө нь гурван голын эхэн орчимд хийсэн археологийн шинжилгээний явцад олдсон хүн дүрст хөшөө чулуудын тухай авч үзсэн ба зарим нэгэн санал дэвшүүлсэн байдаг. Үүндээ нийт 17 хөшөө чулуудыг хамруулан 1. Цулгуй хөшөө, 2. “Овгийн тамга” сийлмэл заримдаг зассан хөшөөнүүд, 3. Хүн төрхт хагас засмал хөшөөнүүд, 4. Хүний нүүрний дүрст хагас засмал хөшөө гэж ангилан үзсэн байна. Эдгээрийг дөрвөлжин булштай ямар нэгэн байдлаар холбоотой гээд гол булшны ойролцоо, дугуй оройтой, дөрвөлжин, өндөр нам, том жижиг байхаас гадна хөшөөний нүүрэн талыг наран жаргах зүгт буюу булшны эсрэг зүгт, булшны зүгт, баруун тийш буруу харуулан зоож тэр хөшөө хэний хөшөө, хэнд зориулсныг илэрхийлсэн байна (Пэрлээ 1977) хэмээжээ.

Хөцөөгийн хүн чулуудыг дөрвөлжин булшны зүүн этгээдэд нүүрийг баруун зүгт харуулан байрлуулж, оройг нь мөн дугуйруулан зассан байхын зэрэгцээ хүний нүүрийг өвөрмөц байдлаар дүрсэлсэн нь дээрхтэй адилсах юм.

Дөрвөлжин булшны ойролцоо хөшөө чулуу босгох зан үйл нь ямартай ч дорнод Монголд нилээд түгээмэл ажиглагдаж байгаа бөгөөд тухайн дурсгалыг үлдээсэн овог аймгийн шүтлэг бишрэлтэй холбоотой бололтой. Х.Пэрлээгийн өгүүлснээр “Бидний итгэмжит өвгөн түүхч Гомбилын Эрдэмбилигийн гэрчлэн мэдээлсэн нь, Дагуурууд үхсэн хүнд босгох хөшөөг шарилын нь хөлд нүүрээр нь хандуулан зооно. Хүний толгойг умард зүг харуулж оршуулдаг гэлээ. Энэ зан үйл их урьдын уламжлалтай байж болох ба дөрвөлжин булштан аймгийн удам угсааг тодотгоход чухалчлагдана” (Пэрлээ 1977:18) гэжээ.



Хадны зураг. Энэхүү хүн чулууны баруун доод ёроолд ромбо хэлбэртэй хавтгай чулуу газраас цухуйсан байдалтай байна. Түүний хамгийн урт нь 118 см, өргөн нь 83 см. Уг чулууны газраас цухуйн харагдаж байгаа дээд талын толигор гадаргуу дээр гол хэсэгт нь хоёр шулуун зураас, зураасны хоёр талаар дөрвөн адууг нуруугаар нь зураас руу хандуулан сийлжээ (Зураг 12. Гэрэл зураг 19)

*Зураг 12. Дорнод аймаг, Гурванзагал сум.
Хөцөөгийн хадны сийлмэл зураг.*

Ер нь Монгол орны зүүн бүсэд ийм төрлийн хадны зураг ховор тохиолддог нь Сүхбаатар аймгийн Онгон сумын нутагт орших Будрын чулуу (Цогтбаатар, Гэрэлбадрах 1997: 66-72), Түвшинширээ сумын нутаг Дэлгэрхаан уулын Цагаан элэгийн (Батсайхан нар, 1998) хадны сийлмэл зургууд юм. Тиймээс энэхүү Хөцөөгийн хадны зураг Дорнод Монголоос олдож байгаа цөөн хадны зургийн тоонд орох бөгөөд энэ үүднээсээ судалгааны өндөр ач холбогдолтой. Тус хадны зургийг үйлдсэн байдлыг Монгол нутаг дахь хадны зургийн дурсгалуудтай харьцуулж үзвэл үйлдсэн арга барил, дүрслэл зэргээрээ хүрэл зэвсгийн үед хамаатуулж болохоор байна (Дорж, Новгородова 1975: 39-44, рис. 8, 13; Цэвээндорж 1999: табл. 30, рис. 10, табл. 40, Рис. 1).

Дөрвөлжин булш (Гэрэл зураг 20А). Хөцөөгийн хүн чулуудаас баруун зүгт 10-аад метрт байх дөрвөлжин булш нь 540х480 см хэмжээтэй зүүн хойш азимутын 10°-т хазайсан байрлалтай. Том хавтгай чулуудыг ирмэгээр нь босгон зоож хашлагыг нь үйлдсэн бололтой бөгөөд 4 булангийн чулуунууд босоогоор үлдэж хашлаганы бусад хэсгийн чулуунууд унасан байдалтай байлаа. Булшны хойд, баруун, урд талаар том хавтгай чулуунууд ихээр унасан байх ба хашлагын дотор төв хэсгээр дараас чулуугүй байгаа нь уг булш эрт цагт тоногдон эвдэгдсэн болохыг харуулж байна. Булшны төв хэсэгт 120 см урт том чулуу ил хэвтэх нь булшны гүнээс гаргасан чулуу бололтой.

Булшны баруун хойд булангийн гозгор хавтгай чулууны гадна талд орой хэсэгт дугуй дүрсийг сийлсэн нь нэлээн бүдэг харагдаж байв (Гэрэл зураг 20Б). Үүнээс өөр ямар нэг дүрс сийлсэн ажиглагдсангүй. Энэхүү чулуун дээрх дүрс уг булшийг үйлдэгч овог аймгийн тамга эсвэл билэгдлийн зүйл байхыг үгүйсгэхгүй бөгөөд зэргэлдээх хүн чулуу, түүн дээр дүрсэлсэн тамга тэмдгийн зүйлтэй нарийн холбоотой болох нь зайлшгүй.

МАЛТЛАГА СУДАЛГАА

ДОРНОД АЙМАГ, ГУРВАНЗАГАЛ СУМ, ЦАГААН ЧУЛУУТ

Цагаан чулуут нь сумын төвөөс зүүн урд зүгт 10 орчим км-т орших боржин хадтай гурван бэсрэг толгой бөгөөд алсаас цагаан өнгөтэй харагддаг тул ийн нэрийддэг ажээ. Энд 160 гаруй оршуулгын байгууламж тоологдсоны дийлэнх нь дөрвөлжин булш байна. Өмнө нь 1969, 1971 онуудад энэ орчимд ШУА-ын түүхийн хүрээлэнгийн “Гурван голын” шинжилгээний анги дөрвөлжин булш малтан судлахын завсар цөөн монгол булш малтаж олон сонирхолтой эд өлгийн зүйлс илрүүлсэн байдаг (Эрдэнэбат, 2007: 219). Үүнээс хойш МУИС-ын Археологи-Антроплогийн тэнхимээс зохион байгуулсан “Дорнод Монгол” шинжилгээний анги 2008 онд Монголын үед холбогдох нэг булш малтан судалснаас гадна Цагаан чулуутын ойр орчимд орших булшнуудын дэвсгэр зургийг үйлдсэн болно (Наваан нар, 2008:18-20). Тус шинжилгээний анги 2009 онд Цагаан чулуутад Монголын үед холбогдох 6 булш малтан судлав. Эдгээр булшнууд нь Цагаан чулуутын гол толгойн урд энгэрт байрлах ажээ.

1-р булш.


N 49° 05' 23,6”

E 115°02' 29,0” Alt 929 m

Газрын хөрсөн дээр цөөн чулуугаар үйлдсэн зууван дугуй хэлбэрийн хавтгай дараастай бөгөөд баруун хойд талаар хэсэг өндөр чулуудтай. Байрлалын хувьд 2009 онд малтсан нийт булшнуудын хамгийн доод захад оршино. Өнгөн хөрсийг нэг үе цэвэрлэхэд хавтгай боржин чулуудаар үйлдсэн цагираг хэлбэрийн дараасны дундаас хүний нурууны нугалам яс, бог малын чөмөгний хугархай илэрч байлаа. Малтлагын гүн 70 см хүрэхэд хойноос урагш чиглэсэн, толгой болон хөл талд чулуун өрлөгтэй, 125х225 см хэмжээтэй оршуулгын нүхний толбо ялгарав (Зураг 13, Гэрэл зураг 21). 75 см гүнд толбоны хөл хэсгээс сэнжийг нь доош харуулан тавьсан, сайн хадгалагдсан төмөр дөрөө илрэв. Түүнээс доош малтах явцад шинэ чулуун зэвсгийн үед холбогдох залтас зэвсэг илэрч байлаа.

162 см гүнээс тэргүүнийг нь зүүн хойд зүг хандуулан тэнэгэр байдлаар тавьсан хүний оршуулга илэрсэн ба зүүн гар талд нь хоромсого тавьсан байв. Нас барагчийн баруун гарыг баруун сүүжин дээр, зүүн гарыг их биеийг дагуулан сарвууг нь саадаг дээр тавьжээ. Саадагны дотор талд 3 ш төмөр зэв, зарим хэсэгт нь сумны мөс хадгалагдан үлдсэн байна. Мөснөөс үзвэл нийт 7 ш сум байсан бололтой. Нас барагчийн зүүн суганд нимгэн, суурьгүй балтгар мөнгөн аягыг бөс даавуугаар ороон тавьсан нь хүнд зүйлд дарагдан нугарсан байдалтай олдов. Баруун мөрний орчим богийн шагай, зүүн хөлийн тавхайн зүүн доод талд булшны дээд хэсгээс илэрсэн төмөр дөрөөний ижил дөрөө (тавгийг эмтэлсэн), зүүн тохойн орчим үйсэн эдлэл зэрэг илэрлээ. Банзан авсанд хийж, тагласан байсан нь ихэд

муудаж, тэмдэг төдий үлджээ. Авсны хөл хэсгээс маш сайн хадгалагдан үлдсэн төмөр эдлэл (авсны таганд байсан бариул бололтой), нимгэн урт, хавтгай ясан эдлэлүүд олон тоогоор илэрсэн нь авсны ясан хяр байсан бололтой. Уг ясан эдлэлүүд ямар нэгэн модон зүйлд уртаар нь хадан тогтоох зориулалттай байсан мэдэгдэж байна (Зураг 14, Гэрэл зураг 22).



Зураг 13. Дорнод аймаг, Гурванзагал сум, Цагаан чулуут 1-р булшны дараас, хөндлөн зүсэлт, оришуулгын толбо, оришуулга

1-р булшны олдворын тодорхойлолт

Хос төмөр дөрөө (Гэрэл зураг 23А). Битүү цутгаж хийсэн, нуман хавирга, дөрвөлжин сэнжстэй, зууван тавагтай. 15 см өндөр, тавагны урт 13 см, өргөн 7 см, сэнжсний өргөн 1.3 см.

Төмөр эдлэл (Авсны бариул байж болох?) (Гэрэл зураг 23Б). Уг төмөр эдлэлийн их бие нь христийн загалмайг санагдуулам хэрээс хэлбэртэй бөгөөд хэрээсийн нэг үзүүрийг салаалуулан уртасгаж тус бүрийн төгсгөлд гогцоо бэхэлжээ. Гогцоонуудыг модон эдлэлд бэхэлж байсан хадаас модны хэсэгтэй хамт олдсон байв. Хэрээсийн хөндлөн шилбэний урт 45 мм, босоо шилбэний урт 34 мм, салаа хүртэл 20 мм, салаануудын урт 40 мм, гогцоонуудын диаметр зүүн талынх 29 мм, баруун талынх 25 мм. Уг төмөр сэнжсний нэг тал нь хавтгай нөгөө тал нь гурвалжин байгаагаас үзвэл ямар нэг зүйлд бэхлэн хэрэглэх зориулалттай байсан нь илэрхий бөгөөд авсны гадна хананд хадаж, авсыг нүх рүү буулгахад хэрэглэсэн байж болох юм. Авсны хананд бэхэлсэн хадаасны дотор талд илүү гарсан үзүүрийг нь 2 тийш эргүүлсэн байсан нь тодорхой мэдэгдэнэ.

Мөнгөн аяга (Гэрэл зураг 23В, Г). Зузаан бөс даавуунд ороолттой олдсон нимгэн мөнгөн аяга. Суурьгүй, хавтгай ёроолтой. Аяганы амсрыг тойруулан 1 см өргөнтэй усан хээ, түүний завсар зайгаар хэрээс тэмдгийг багтаан цохисон, усан хээний дээгүүр болон доогуур нарийн зураас гарган эмжжээ. Аяганы хэмжээ өндөр нь 5 см, нугарсан байдлаар урт нь 19,2 см, хамгийн их өргөн 10,5 см.

Ясан чимэглэл (Гэрэл зураг 23Е). Ямар нэгэн зүйлийг эмжих чимэглэх зориулалтаар хэрэглэгдэж байсан бололтой 9-11 мм өргөн 2 мм зузаантайн урт хавтгай ясан эдлэлүүд. Ясыг засаж нарийн хавтгай болгоод нэг талд нь хээ гарган чимэглэсэн байх ба нийт 18 хугархай хэсэг олдсоноос огт хээгүй, нэг талд нь ховил гаргасан, хоёр талд нь ховил гаргасан, нэг талыг гурвалжин дүрсээр чимсэн гэх мэт 4 янзын чимэглэлтэй байна. Зарим хугархай хэсгүүд ясан хадаастай олдсоноос үзэхэд уг чимэглэлийг ясан хадаасаар тогтоож байсан бололтой.




Зураг 14. Дорнод аймаг, Гурванзагал сум, Цагаан чулуут. 1-р булшны олдворууд: Дөрөө, төмөр эдлэл, богийн шагай, мөнгөн аяга

2-р булш.


N 49° 05' 24.6"

E 115°02' 29.0" Alt 927 м

1-р булшнаас дээш 10 метрт цөөн хэдэн чулуудаар мэдэгдэх ба голдоо чулуугүй, цагираг хэлбэрийн дараастай (Зураг 15, Гэрэл зураг 23А). Малтлагын гүн 60 см хүрэхэд зүүн хойш чиглэсэн нарийн толбо илэрсэн бөгөөд толбоны дээд хэсэгт том чулуу тавьсан байлаа. Цааш малтахад 1,2 м гүнд толбоны дунд хэсгээс улаан өнгийн жижиг залтас илрэв. Цэвэрлэгээний явцад дараасны хойд хэсгээс төмөр зэвний хэсэг, хар өнгийн ваар савны хагархай хэсгүүд, малын чөмөгний яс гарлаа. Малтлагын явцад булшны хөл хэсгээс нимгэн ясан эдлэлийн хугархайнууд олдож байлаа. Мөн энэ орчмоос неолитийн чулуун залтас болон төмөр зэв, муу хадгалагдсан төмрийн бааснууд, бүсний хүрэл арал олдов (Зураг 16, Гэрэл зураг 23Б). 1,5 м гүнээс үйсэн саадагны хугархай, нимгэн ясан эдлэлийн хэсгүүд, зориулалт нь тодорхойгүй төмөр эдлэл, хүний эрүү, нугалам, хавирга эмх замбараагүй байдалтай олдож байв. Нас барагчийн цээжин доороос 3 ш богийн нурууны яс анхны байрлалаараа олдлоо. Нас барагчаа модон авсанд оршуулсан бололтой ба ихэд эвдэгдэн тоногдсон булш байв.



Зураг 15. Дорнод аймаг, Гурванзагал сум, Цагаан чулуут 2-р булшны дараас



Зураг 16. Дорнод аймаг, Гурванзагал сум, Цагаан чулуут 2-р булшны олдворууд

2-р булшны олдворын тодорхойлолт

Төмөр зэв. Шилбэтэй нийт урт 10.5 см, толгойн өргөн 2 см

Бүсний хүрэл арал. Дөрвөн өнцөгт дэлбээ маягийн шонтонтой, хоёр захад төмөр хадаас нэвт хадсан. 20 x 25мм

Ясан чимэглэл. Нимгэн урт хавтгай ясан эдлэл. 10 мм өргөнтэй, 1,5 мм зузаантай. Ямар нэг зүйлд бэхлэн чимэглэх зориулалттай бололтой. Хоёр төрөл олдсон бөгөөд эхнийх нь элдэв чимэггүй, гурвалжилж зассан байдалтай. Удаах нь хоёр захаар нь шулуун зураас татаж голоор нь долгио хээ сийлсэн. Аль аль нь хадаасны нүхтэй, нүх хоорондын зай дунджаар 2.5 см. Уг чимэглэлийг ойролцоогоор 1.5 см урт, нарийн шөвхөлж хийсэн ясан хадаасаар тогтоосон байжээ.

Төмөр сэнж. 2-р булинаас гарсан төмөр эдлэлийг сэргээн засварлаад эвлүүлж үзэхэд 1-р булинаас гарсан төмөр бариулын адил эдлэл байсан бөгөөд хэмжээгээр ялимгүй бага байв.


Шагай. Богийн шагай, эр эргүүлэгтэй

3-р булш.

N 49° 05' 25.5"

E 115°02' 28.5"

Alt 921 м



Зураг 17. Дорнод аймаг, Гурванзагал сум, Цагаан чулуут. 3-р булшны дараас, таглаа чулуу, оршуулга


Том хавтгай чулуудыг давхарлан дугуй хэлбэртэйгээр өрсөн жижгэвтэр булш. Дараасны төв хэсэгт зүүн хойд зүг чиглэсэн гонзгой, дөрвөлжин хэлбэрийн өрлөг мэдэгдэж байв (Зураг 17, Гэрэл зураг 24А). Түүнийг доош малтахад оршуулгын нүхийг 0.9 х 1.5 м дөрвөлжин хэлбэрийн том хавтгай чулуугаар таглан хамгаалсан байв. Тэрхүү хавтгай чулууны доод болон зүүн талын нимгэн хэсэгт сэт цохин эмтэлсэн байснаас харахад тонуулчид дараас чулууны хөл талаас шурган орсон бололтой. Малтлагын явцад 80 см хүртэл чулуун залтас, хүний шаант болон хавирга яснууд, богийн чөмөгний ясаар хийсэн эдлэл, авсны төмөр хадаас зэрэг зүйлс илэрч байсан ба 1.6 м гүнд хүний толгойн яс, сүүж, нуруу, хурууны үе яс гэх мэт яснууд эмх замбараагүй байдалтай, төмөр эдлэлийн үлдэгдэл, чулуун залтас зэрэг зүйлс илэрч байлаа (Гэрэл зураг 24Б). Булшны нүхний толгой талаас босгон тавьсан богийн шагайт чөмөг, дунд хэсгээс ясаар хийсэн бэл 4 ш, 3 ш төмөр зэвтэй үйсэн саадаг, хавтгай хүрэл эдлэл нугаларсан байдалтай, модны хэсгүүд олдов (Зураг 18, Гэрэл зураг 24В). Антропологийн материалаас үзвэл насанд хүрсэн эрэгтэй хүний оршуулга байлаа.

3-р булшны олдворын тодорхойлолт

Ясан эдлэл. Богийн чөмөгний ясыг тууш зүсэж хийсэн хавтгай ясан эдлэл. Зориулалт тодорхойгүй. 10.4 см урт, 4,5 мм зузаан, их бие болон нэг талын үзүүрийн өргөн 13 мм, нөгөө талын үзүүр рүүгээ өргөссөн 22 мм өргөн.

Ясан бэл. 4 ш. Ямар нэгэн зүйл голоор нь хөврөх зориулалттай нарийн хөвлүүртэй, дугуйвтар хэлбэртэй бөгөөд 2 нь сэнжстэй, 2 нь сэнжсгүй. Хэмжээ 3.2 см өргөн, 3.3 см урт, сэнжсний урт 1.2 см. Нэг нь хэмжээгээр бусдаасаа жижиг сэнжсгүй, урт 2.5 см, өргөн 2 см. Бүгд ирмэгээрээ нарийн зураасаар хөвөөлж, дотуур нь гурвалжин дүрсээр чимэглэсэн хээтэй.

Үйсэн саадаг. Хадгалалт сайн, 43 см урт.



Зураг 18. Дорнод аймаг, Гурванзагал сум, Цагаан чулуут. 3-р булшны олдворууд. А. Ясан эдлэл, Б. Ясан бэл, В. Төмөр гогцоо, Г. Төмөр арал, Д. Төмөр зэв

Хавтгай хүрэл эдлэл. Ямар нэгэн зүйлд хадан тогтоох зориулалтаар 4 өнцөгт зориудаар нүх гарган цоолсон бөгөөд анхны хэлбэрээ алдан нугаларсан байдалтай олдсон ба хавтгай төмрийн үлдэгдлүүдтэй хамт илэрсэн. 3.3 см өргөн, 2.8 см урттай

Төмөр цагариг (Авсны бололтой?). Ямар нэгэн модон зүйлд хадах зориулалт бүхий цагариг төмөр эдлэл, цүүтэй. Цүүн дээр нь модонд бэхэлж байсан ул мөр үлдсэн. Уг эдлэл нь 1-р булшаас гарсан төмөр эдлэлтэй адил зориулалттай бололтой.

Төмөр арал. Урт 3.3 см. Өргөн 1.8 см. Голоороо хэлтэй.

Төмөр зэв. 1-р зэв 15 см. Сурвалжны урт 8.5 см. Толгойн өргөн 3.2 см.

2-р зэв 16 см. Сурвалжны урт 9.8 см. Толгойн өргөн 2.8 см.

3-р зэв шилбэггүй, 5.5 см урт, 3.7 см өргөн.


4-р булш.

N 49° 05' 22.1"

E 115° 02' 31.4" Alt 920 м

4 м диаметртэй, голдоо чулуугүй бөгөөд зууван дугуй дараастай булш. Цэвэрлэгээний явцад адууны шүд, неолитийн үеийн үлдцүүд илэрч байлаа. 1.62 гүнээс хүний эрүү, сүүж зэрэг бусад яснууд маш эмх замбараагүй байдалтай илрэв. Нүхний төв хэсгээс жижиг цагаан чулуун шигтгээтэй мөнгөн сүүжин ээмэг 2 ш олдсон ба цээж хэсэгт богийн 3 ш нуруу, толгой хэсэгт төмөр үйлийн хайч олдов.

Хүний хөлийн яснууд анхны байрлалаа хадгалан үлдсэн байлаа. Уг булш нь настай эмэгтэй хүний оршуулга байсан ба ихэд тоногдон эвдэгдсэн байв (Зураг 19, Гэрэл зураг 25).



Зураг 19. Дорнод аймаг, Гурванзагал сум, Цагаан чулуут, 4-р булш. Дараас, Оршуулга, Олдворууд: Мөнгөн сүүжсин ээмэг (хос), үйлний төмөр хайч

4-р булшны олдворын тодорхойлолт

Үйлний хайч. Үзүүр хэсэг нь хугарсан. Одоо байгаа урт 14.5 см.


Хос мөнгөн ээмэг. Урт 5 см. Цагаригны диаметр 2 см. Доод унжлагад жижиг цагаан чулуун шигтгээтэй.

5-р булш

N 49° 05' 25.8"

E 115° 02' 25.8" Alt 924 м

Малтсан булшнуудын хамгийн хойно орших 4.5 м диаметртэй, дугуй хэлбэрийн чулуун дараастай булш. Тоногдсон гэх шинж тэмдэггүй. 50 см гүнээс 1.85x0.8 м хэмжээтэй зүүн хойд зүг чиглэсэн толбо илрэв. Энэ хэсгээс чулуун зэвсгийн үлдцүүд, адууны шүд илэрч байсан ба 96 см гүнд зүүн хойд зүг хандуулан тэнэгэр байдалтай оршуулсан эмэгтэй хүний оршуулга илрэв (Зураг 20, Гэрэл зураг 26). Толгойд нь богтого малгайн суурь хэсэг наалдан хадгалагдан үлдсэн байна. Толгойн баруун талаас хүрэл сүүжин ээмэг, зүүн тохойн дээр богийн чөмөг, баруун тохойн дээр богийн дал тус тус дагалдуулжээ. Мөн баруун тохойн доороос муу хадгалагдсан төмөр эдлэл илэрсэн болно.



Зураг 20. Дорнод аймаг, Гурванзагал сум, Цагаан чулуут. 5-р булш. Чулуун дараас, хөндлөн зүсэлт, оршуулга, олдворууд: богтаг малгайн үйсэн суурь, хүрэл ээмэг


5-р булшны олдворын тодорхойлолт

Ээмэгний хүрэл унжуурга. Урт нарийн хүрлээр нэг үзүүрт нь гогцоо гарган үйлдсэн. Урт нарийн хүрэл утсаар нэг үзүүрт цагираг гогцоо гаргаж хийсэн. Нөгөө үзүүрийг ээмэгний доод үзүүрт тогтоох зориулалтаар тахийлгажээ. Нийт урт 3.3 см. Цагаригны диаметр 1 см. Шилбэний урт 2.2 см. ээмэгний нэмэлт унжуурга бололтой.

Богтаг малгайн үйсэн суурь. 10.5 см өргөн, 10 см урт хэмжээтэй. Хавтгай үйсийг дугуйруулан 2 үзүүрийг хооронд нь холбосон.

163-р булш

Энэ онд малтсан булшнуудын хамгийн зүүн урд талд байрлах ба 3.5 м диаметртэй цагираг дараастай булш (Зураг 21, Гэрэл зураг 27А). Цэвэрлэгээний явцад бог малын чөмөгт ясны хугархайнууд, чулуун зэвсгийн үлдцүүд илэрч байлаа. 115 см гүнээс анатомийн байрлалаа хадгалан үлдсэн хүний хөлийн яснууд болон шуу, гавал, хэсэг хавирга яснууд эмх замбараагүй байдалтайгаар илэрлээ. Хүнийг банзан авсанд хийж оршуулсан нь малтлагын явцад харагдаж байсан ба гавлын ясны зүүн хажууд хүрэл толийг жижиг төмөр хайчны хамт бөс даавуу болон эсгийнд давхар ороон дагалдуулсан байв (Гэрэл зураг 27Б). Малтлагын явцад олон тооны жижиг чулуун сувснууд, ясан унжлага илэрсэн ба нас барагчийнхаа доор эсгий дэвсэж оршуулсан нь тодорхой мэдэгдэж байлаа.



Зураг 21. Дорнод аймаг, Гурванзагал сум, Цагаан чулуут. 163-р булш. Дараас чулуу, оршуулга

163-р булшны олдворын тодорхойлолт

Хүрэл толь: Монгол хийцийн хүрэл толь 8 см диаметртэй

Чулуун сувс, ясан унжлага. Ясан унжлага 1 ш - 8,5 мм урт, 4 мм өргөн. Жижиг амьтны ясаар нэг талд нь нэвт нүх гаргаж хийсэн, дусал маягийн хэлбэртэй. Чулуун сувс нийт 33 ширхэг, 1,5 -2,5 мм хэмжээтэй, ногоон өнгөтэй.

Төмөр хайч: Нилээд зэвэрч муудсан. Хайчны одоо байгаа урт 9 см, өргөн нь 5.5 см

Хүснэгт 1. Дорнод аймаг, Гурванзагал сум, Цагаан чулуутад малтсан Монголын үеийн булшны харьцуулсан хүснэгт

№	Булшны дугаар	Дараасны хэлбэр	Булшны нүхний чиглэл	Нүхний гүн	Хүнээ тавьсан чиглэл, байдал	Олдвор	Малын яс	Зан үйл	Тайлбар
1	1-р булш	Голдоо чулуугүй цагариг дараастай	Уртрагийн дагуу	162 см	Зүүн хойд зүг хандуулан тэнэгэр байдлаар	3 ш төмөр зэв, бөс даавуугаар ороосон нимгэн, суурьгүй мөнгөн аяга, хос төмөр дөрөө, үйсэн эдлэл, төмөр эдлэл, нимгэн урт хавтгай ясан эдлэлүүд	Богийн шагай	Хүнээ банзан авсанд оршуулсан	
2	2-р булш	Голдоо чулуугүй, цагариг дараастай	Зүүн хойш чиглэсэн	151 см	Хүний эрүү, нугалам, хавирга эмх замбараагүй байдалтай	Төмөр зэв, хар өнгийн ваарны хагархай хэсгүүд, төмрийн баас, үйсэн саадагны хугархай, ясан эдлэлийн хугархай	Богийн 3 ш нуруу, малын чөмөгний яс	Нас барагчаа модон авсанд оршуулсан	Маш их тоногдсон
3	3-р булш	Цагариг дараастай		160 см	Хүний гавал, сүүж, нуруу, хурууны яс эмх замбараагүй олдсон	Авсны төмөр хадаас, ясан бэл 4 ш, үйсэн саадаг, 3 ш төмөр зэвтэй саадаг, хавтгай хүрэл эдлэл, модны хэсгүүд	богийн шагайт чөмөг	Дараасны дунд хэсэгт дөрвөлжин хэлбэрийн өрлөгтэй, Булшны нүхийг том хавтгай чулуугаар тагласан, Булшны нүхний толгой талд богийн шагайт чөмөг босгон тавьсан	

4	4-р булш	Голдоо чулуугүй зууван дараастай		162 см		Жижиг цагаан чулуун шигтгээтэй 2 ш мөнгөн ээмэг, төмөр үйлний хайч	Богийн 3 ш нуруу, адууны шүд		
5	5-р булш	Цагариг дараастай булш	50 см гүнд 1.85х0.8 м хэмжээтэй зүүн хойд зүг чиглэсэн толбо	96 см	Хойд зүг хандуулан тэнэгэр байдалтай	Богтаг малгайн үйсэн суурь хэсэг, хүрэл ээмэг, муу хадгалагдсан төмөр эдлэл	Богийн дал, богийн чөмөг		
6	163-р булш	Цагариг дараастай		115 см	хүний хөлийн яснууд анатомийн байрлалаа хадгалан үлдсэн, шуу, толгой, хавирга яснууд эмх замбараагүй байдалтайгаар илэрсэн	Даавуунд ороосон хүрэл толь, 2 ш хүрэл зэв		Хүнийг банзан авсанд хийж оршуулсан. Хүний доор эсгий дэвссэн	

Цагаан чулуутад малтсан булшууд газрын хөрсөн дээр цөөн чулууд цухуйж мэдэгдэх бөгөөд эхний үеийн цэвэрлэгээг хийж үзэхэд ихэнх булш зууван цагираг хэлбэрийн дараасыг дунд зэргийн хавтгай чулуугаар үйлдсэн байв. 2, 3, 4, 163-р булш зохион байгуулалтаа ямар нэгэн байдлаар алдаж тоногдсон шинжтэй. Нийт булшны нүхний гүн 96 см-ээс 162 см хооронд хэлбэлзэх бөгөөд хүний толгойг хойд болон зүүн хойд зүгт хандуулан тавьсан байлаа. Оршуулгын зан үйлийн хувьд 1, 2-р булшинд хүнээ модон авсанд хийж оршуулсан нь мэдэгдэж байв. Мөн 3-р булшинд нүхний хойд хэсэгт богийн шагай чөмөг, 2-р булшинд богийн 3 ш нуруу, чөмөгний яс, мөн 4-р булшинд богийн 3 ш нуруу, адууны шүд зэрэг малын яс дагалдуулан тавьжээ. Булшинд янз бүрийн малын яс дагалдуулан тавихаас гадна богийн шагай чөмгийг босгож тавих ёс нь МЭ VII зууны үеэс бий болсон оршуулгын зан үйлийн онцлог юм (Коновалов, Именохоев, 1982: 128-130). Судлаачид энэхүү зан үйлийг эртний монголчуудтай холбон тайлбарладаг ба МЭ I мянганы дунд үед Өвөрбайгальд бий болж хэлбэршин хойцегорийн (VII-X зуун), саянтуйн (X-XIV зуун) гэх хоёр шатыг дамжин хөгжихдөө Ар Байгальд I мянганы сүүлчээс түгж, харин Өвөр Байгалийн дорнод хэсэгтэй нилээд эртнээс нягт холбоотой байсныг тэмдэглэдэг (Төрбат, Батсайхан, 2006: 110-116).

Цагаан чулуутын булшнуудад эрэгтэй хүнд гол төлөв төмөр дөрөө, зэв, үйсэн саадаг, эмэгтэй хүнд ээмэг, богтаг малгай, үйлний хайч, хүрэл толь зэргийг дагалдуулсан нь дундад эртний булшнаас олддог нийтлэг эд өлгийн зүйлс болно. Харин 1-р булшнаас гарсан зарим олдворууд онцлог байв. Тухайлбал, энэ булшнаас гарсан аягатай төстэй мөнгөн аяга өмнө нь Өвөрхангай аймгийн Богд сумын Ховд багийн нутаг Бага Тэвш ууланд малтсан XIII-XV зууны үеийн булшнаас олдсон мэдээ байдаг (Эрдэнбат, 2007: 219). Мөн энэ булшны хөл орчмоос илэрсэн төмөр эдлэл хэлбэр дүрсийн хувьд нилээд сонирхолтой олдвор юм. Бидний төсөөлж буйгаар түүнийг авсны хөл, толгой орчимд хадаж бэхлэн авсыг доош буулгах урт уяаг оосорлоход хэрэглэж байсан бололтой бөгөөд хоёр үзүүрийн нь хос цагиргыг ороосон төмөр цүү модны хэсэгтэй олдсоноос уг эдлэлийг модонд бэхэлж байсан нь мэдэгдэнэ. Энэ эдлэлийн их бие христийн загалмай мэт хэлбэртэй, түүнчлэн энэ булшнаас олдсон мөнгөн аяганы амсрын хээний дунд мөн загалмайн дүрслэл давтагдаж байгаа нь энэхүү булшинд оршуулсан хүний шүтлэг бишрэлийг илтгэж буй баримт байж болох юм. Сүүлийн үеийн судалгаагаар манай улсын нутагт малтсан дундад эртний үед холбогдох булшнаас христийн загалмай, түүнтэй холбогдох олдвор цөөнгүй олдож (Эрдэнэбат, 2009) байгаагаас үзвэл дундад эртний үеийн овог аймгууд олон шашин тэр дундаа христийн янз бүрийн урсгалыг шүтдэг байжээ. Тэрчлэн Монголын их хаад бүх шашинд адил тэгш хандах бодлогыг хэрэгжүүлж байсан нь нилээд эртний уламжлалтай аж. Үүнийг дан ганц археологийн хэрэглэгдэхүүнээс гадна сурвалж бичгийн мэдээ мөн давхар гэрчилдэг (Энхчимэг, 2009).

Сурвалжид бичсэнээр энэ бүс нутагт дундад эртний үед Татаарын ханлиг голчлон нутаглаж байсан бөгөөд энэ тухай “... тэдний нутаг, сууц нь хятадын

хилийн орчмоор (харин) үндсэн нутаг нь Буйр нуур билээ ...” хэмээн тэмдэглэжээ (Батсүрэн, 2003: 74).

Цагаан чулуутад малтсан булшнуудын зан үйл хийгээд олдворуудын байдлыг үзвэл Монгол болон Өвөрбайгальд малтсан дундад эртний булшны хэрэглэгдэхүүнтэй ерөнхийдөө адил байх бөгөөд голчлон зэр зэвсгийн, адууны тоног хэрэглэл, гоёл чимэглэл зэрэг зүйлсийг дагалдуулан тавьжээ (Хүснэгт 1).

Манай улсын нутагт 2006 оны байдлаар дундад эртний үеийн Монголчуудын булш нийт 247, хадны оршуулга 41 малтан шинжилсэн гэсэн тооцоог доктор У.Эрдэнэбат гаргасан байдаг. Тэдгээр дурсгалын он цагийг ерөнхийд нь булшны гадаад, дотоод зохион байгуулалт, үхэгсдийг оршуулах зан үйлийн тогтвортой шинж, хойлгын эд зүйлсийн онцлог зэргийг харьцуулах аргаар тогтоосон бөгөөд харин орчин үеийн байгалийн шинжлэх ухааны аргаар (C14) үнэмлэхүй он цагийг тодорхойлсон 14 булш, хадны оршуулга 8 байна (Эрдэнэбат, 2007:235). Энэ үед холбогдох булшны малталга судалгаа өнөө үед тасралтгүй хийгдэж судалгааны хэрэглэгдэхүүн нэмэгдсээр байгаа (Харинский, 2009: 99-104) бөгөөд бидний 2009 онд малтан шинжилсэн булшны хэрэглэгдэхүүн мөн эдгээрт хамаарах юм.

Ийнхүү “Дорнод Монгол” төслийн хүрээнд манай улсын Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгуудын нутагт явуулдаг археологийн хээрийн судалгаагаар жил бүр хэдэн арван дурсгал, олдворыг илрүүлэн олж шинжлэх ухааны эргэлтэнд оруулж байгаа нь монголын археологи, тухайлбал, Дорнод Монголын бүс нутагт эрт үеэс оршин амьдарч байсан эртний нүүдэлчдийн түүх, соёл, угсаа гарвалын асуудлыг судлахад чухал хэрэглэгдхүүн болох юм. 2009 онд болон урд жилүүдэд хийгдсэн судалгаанаас харахад Дорнод Монголын тал нутаг эрт үеийн нүүдэлчдийн ул мөр, үе үеийн дурсгал, хэрэглэгдэхүүнийг хадгалсан Монголын түүхийн хувьд чухал бүс нутаг болох ажээ.

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааг явуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн МУИС-ийн Азийн судалгааны төв, Солонгосын ахисан түвшний судалгааны санд талархал илэрхийлье.

НОМ ЗҮЙ

- Амартүвшин Ч., Ерөөл-Эрдэнэ Ч., Гүнчинсүрэн Б., Цогтбаатар Б., 2007. Эртний нүүдэлчдийн оршуулгын зан үйлийн өвөрмөц нэгэн хэлбэр. SA. Tom (IV) XXIV. Fasc. 11, т. 141
- Амартүвшин Ч., Гүнчинсүрэн Б., Ерөөл-Эрдэнэ Ч., Гантулга Ж., Амгалантөгс Ц., Жаргалан Б., 2008. Ухаа худагт хийсэн археологийн малтлага судалгааны үр дүн. SA. Tom (VI) XXVI. Fasc. 11
- Амартүвшин Ч., Жаргалан Б., 2008. Бага газрын чулуунд хийсэн хүрэл зэвсгийн түрүү үеийн булшны судалгаа. SA. Tom (VI) XXVI. fasc. 5
- Батсайхан З., 2002. Хүннү /Археологи, угсаатны зүй, түүх/. УБ

- Батсайхан З., Төрбат Ц., Эрдэнэбат У., 1998. Цагаан элэгийн хадны зураг. МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг. № 4(133). УБ.
- Батсүрэн Б., 2003. Монголын эртний улсуудын нутаг дэвсгэр (Түүхэн газар зүйн шинжилгээ). УБ.
- Боровка Г.И., 1927. Археологическое обследование среднего течения р. Толы. Северная Монголия. Вып. II. Л.
- Волков В.В., 1967. Бронзовый и ранний железный век Северной Монголии. УБ.
- Гришин Ю.С., 1980. О фигурных плиточных могилах Забайкалья и Монголии. КСИА. Вып. 162
- Диков Н.Н., 1958. Бронзовый век Забайкалья. Улан-Удэ
- Дорж Д., 1971. Неолит Восточной Монголии. УБ
- Дорж Д., Новгородова Э.А., 1975. Петроглифы Монголии. УБ.
- Киселев С.В., 1947. Монголия в древности. Известия АН СССР. Том. IV. Вып. 4. М.
- Коновалов П.Б., Именохоев Н.В., 1982. Об изучении средневековых памятников Западного Забайкалья. Проблема археологии и этнографии Сибири. Иркутск.
- Наваан Д., Эрдэнэ М., Хатанбаатар Д., Түмэн Д., 2008. “Дорнод монгол” төслийн хүрээнд 2008 онд хийж гүйцэтгэсэн археологийн хээрийн судалгаа. Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology, Volume 4, № 1(312) December 2008.
- Новгородова Э.А., 1989. Древняя Монголия. М.
- Окладников А.П., Крилов И.И., 1980. Юго-Восточное Забайкалье в эпоху камня и ранней бронзы. Новосибирск.
- Пэрлээ Х. 1977. Хүн чулуун хөшөөний үүсэл хувьслыг судлах тухай. СА., Том VII, Fasc. 2, х. 14-19. УБ.
- Сэр-Оджав Н., 2003. Археологические разведки в Восточном аймаке МНР в 1962. Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхтгэл. УБ.
- Сосновский Г.П., 1941. Плиточные могилы Забайкалья.ТОИПК ГЭ. Т1
- Сосновский Г.П., 1928. Фигурные могилы. Материалы. Архив Г.П.Сосновского. Архив. ИИМК. АН. Ф-42. №251. (дам ишлэв)
- Төрбат Ц., Батсайхан З., 2006. Эртний Монголчуудын археологийн дурсгалыг судлах асуудалд (МЭ VIII-XV зуун). Монголын археологи, эртний түүхийн сургалтын хэрэглэгдэхүүн. УБ.
- Төрбат Ц., 2004. Эрдэнэхайрхан уулын булш ба дөрвөлжин булшны соёлыг үечлэх асуудалд. АН. Том V. Fasc. 1.
- Түмэн Д., Наваан Д., Эрдэнэ М., Хатанбаатар Д., 2008. Өмнөговь аймгийн Номгон сумын Цагаан толгойд хийгдсэн археологийн малтлага судалгааны ажлын тайлан. МУИС-ийн Археологи-Антроплогийн Тэнхмийн ГБСХ
- Харинский А.В., 2009. Хөвсгөл аймгийн Ханх сумын нутагт явуулсан археологийн судалгааны үр дүн. Eastern Mongolia and Northern Culture. 2nd International Conference. April, 2009. Ulaanbaatar State University. т. 99-105
- Цогтбаатар Б., Гэрэлбадрах Ж., 1997. Бударын чулууны хадны зураг. СА. Том XVII, Fasc. 5. УБ.
- Цэвээндорж Д., 1999. Эртний урлагийн түүх. УБ.
- Цэвээндорж Д.,Амартүвшин Ч., Гүнчинсүрэн Б., Цогтбаатар Б., Батболд Н., Ерөөл-Эрдэнэ Ч., Базаргүр Д., Болорбат Ц., Гантулга Ж., 2005а. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь “Айвенхоу Майнз Монголия Инк” компаний ашиглалтын талбайд хийсэн малтлага судалгааны ажлын тайлан. ШУА, АХ ГБСХ.
- Цыбиктаров А.Д., 1998. Культура плиточных могил Монголии и Забайкалья. Улан-Удэ.
- Энхбат.Г., Даваацэрэн Б., 2009. Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгал. Дорнод аймаг. III дэвтэр. УБ.
- Энхчимэг Ц., 2009. Монголын хаадын бүх шашинд адил тэгш хандах бодлогын мөн чанар. УБИС. НУФ. Нийгмийн шинжлэх ухааны эрдэм шинжилгээний бичиг. №5(4). УБ.
- Эрдэнэбаатар Д., Ковалев.А.А., 2009. Тэвшийн соёл. УБИС. НУФ. Нийгмийн шинжлэх ухааны эрдэм шинжилгээний бичиг. 4(3). УБ

Д.НАВААН, Д.ТҮМЭН, М.ЭРДЭНЭ, Д.ХАТАНБААТАР, Г.АНХСАНАА

Эрдэнэбат У., 2007. Монгол улсын нутаг дэвсгэрт дундад зууны Монголчуудын булш, оршуулгын дурсгалыг судалсан тойм. Боть 32. Монголын археологийн шинжлэх ухаан. Монгол улсын шинжлэх ухаан. 108 боть цуврал. УБ.

Эрдэнэбат У., 2009. Дундад зууны Монгол оронд загалмайтны шашны урсгал нэвтэрч байсан товч түүхээс. УБ.

SUMMARY

D.Navaan, D.Tumen, M.Erdene, D.Khatanbaatar, G.Ankhsanaa

ARCHAEOLOGICAL FIELDWORK IN 2009 WITHIN THE RESEARCH PROJECT “EASTERN MONGOLIA”

During the fieldwork in 2009, the expedition team conducted an extensive survey in Khentii, Sukhbaatar and Dornod aimags and excavated 17 ancient graves and one Neolithic site. Excavation of graves at Ulaan Zuukh site, revealed unusual burial ritual to bury deceased face down, and thus will be an important site in the question of cultural and ethnic relationship of “*slab graved*” and “*figure graved*” ancient populations from Bronze Age period. By the excavation of graves at Tsagaanchuluut site, Gurvanzagal soum, Dornod aimag, various artefacts are found demonstrating traditional culture, religion and social status of ancient nomads from Mongolia and Baikal region.



Гэрэл зураг 1. Сүхбаатар аймаг, Түвшинширээ сум, Булгийн довжоо. Ерөнхий байдал



Гэрэл зураг 2. Сүхбаатар аймаг, Түвшинширээ сум, Улаан зуух. 5-9-р булш.



А.



Б.



В.

Гэрэл зураг 3. Сүхбаатар аймаг, Түвшинширээ сум, Улаанзуух. 5-р булш.
А. Гадаад зохион байгуулалт, Б. Чулуун дараас, В. Оршуулга



А.



Б.



В.

Гэрэл зураг 4. Сүхбаатар аймаг, Түвшинширээ сум, Улаанзуух, 6-р булш.
А. Гадаад зохион байгуулалт. Б. Чулуун хашлага, В. Чулуун өрлөг



А.



Б.

Гэрэл зураг 5. Сүхбаатар аймаг, Түвшинширээ сум, Улаанзуух, 7-р булш.
А. Гадаад зохион байгуулалт. Б. Чулуун хашлага, оршуулга



А.



Б.

Гэрэл зураг 6. Сүхбаатар аймаг, Түвшинширээ сум, Улаанзуух.
А. 8-р булш. Гадаад зохион байгуулалт, Б. 9-р булш – тахилгынбайгууламж.



Гэрэл зураг 7. Сүхбаатар аймаг, Түвшинширээ сум, Улаанзуухын цогцолборт
орших чулуун байгууламж



Гэрэл зураг 8. Сүхбаатар аймаг, Түвшинширээ сум, Улаанзуух, 5-р булшны чулуун
хашлагын зохион байгуулалт



Гэрэл зураг 9. Сүхбаатар аймаг, Түвшинширээ сум, Их хөмөг 1-р булш



Гэрэл зураг 10. Сүхбаатар аймаг, Мөнххаан сум, Барга элс. Неолитийн үеийн бууцны сорилтын малтлага



Гэрэл зураг 11. Сүхбаатар аймаг, Мөнххаан сум, Барга элс 1-р булш. Гадаад зохион байгуулалт




Гэрэл зураг 12. Хэнтий аймаг Баян Овоо сум, Майхант толгойгоос илрүүлсэн түүвэр олдворууд



Гэрэл зураг 13. Хэнтий аймаг. Баян Овоо сум, Майхант толгой. 1-р булш.
Толбо, Оршуулга



А.



Б.



В.

Гэрэл зураг 14. Хэнтий аймаг. Баян Овоо сум, Майхант толгой. 1-р булш.
Олдворууд

А. Хүрэл зэв, Б. Чулуун сувс, В. Төмөр эдлэлийн үлдэгдэл



Гэрэл зураг 15. Дорнод аймаг, Булган сум, Холбоо хоёр. 1-р булш . Гадаад зохион байгуулалт



Гэрэл зураг 16. Дорнод аймаг, Булган сум, Холбоо хоёр. 2-р булш .
Чулуун хашлага, Ваар



Гэрэл зураг 17. Дорнод аймаг, Булган сум, Холбоо хоёр.3-р булш .
Хүүхдийн гавал, улаан лак



А.



Б.



В.



Г.

Гэрэл зураг 18. Дорнод аймаг, Гурванзагал сум. Хөцөөгийн хүн чулууд
А. 1-р хүн чулуу, Б. 2-р хүн чулуу (баруун талаас), В. 2-р хүн чулуу (зүүн талаас), Г.
2-р хүн чулууны ард зурсан тамга



Гэрэл зураг 19. Дорнод аймаг, Гурванзагал сум. Хөцөөгийн хадны зураг



А.



Б.

Гэрэл зураг 20. Дорнод аймаг, Гурванзагал сум. Хөцөөгийн дөрвөлжин булш, түүний хашлага чулуун дээр зурсан тамга



А.



Б.

Гэрэл зураг 21. Дорнод аймаг, Гурванзагал сум, Цагаан чулуут. 1-р булш.
А. Гадаад зохион байгуулалт, Б. Толбо



А.



Б.



В.



Г.



Д.



Е.

Гэрэл зураг 22. Дорнод аймаг, Гурванзагал сум, Цагаан чулуут.1-р булшны олдворууд: А. Төмөр дөрөө, Б. Төмөр сэнж, В. Аяга ороосон даавуу, Г. Мөнгөн аяга, Д. Үйсэн саадаг, Е. Ясан чимэглэл



А.



Б.

Гэрэл зураг 23. Дорнод аймаг, Гурванзагал сум, Цагаан чулуут 2-р булш .
А. Гадаад зохион байгуулалт, Б. Ясан эдлэл



А.



Б.



В.

Гэрэл зураг 24. Дорнод аймаг, Гурванзагал сум, Цагаан чулуут 3-р булш .
А. Гадаад зохион байгуулалт, Б. Оршуулга В. Олдворууд: Бүсний ясан бэл, Хавтгай хүрэл эдлэл



А.



Б.

Гэрэл зураг 25. Дорнод аймаг, Гурванзагал сум, Цагаан чулуут 4-р булш.
А. Гадаад зохион байгуулалт, Б. Олдворууд. Үйлийн төмөр хайч, Мөнгөн эзэмэг



Гэрэл зураг 26. Дорнод аймаг, Гурванзагал сум, Цагаан чулуут 5-р булш .
А. Оршуулга, Б. Олдворууд. Хүрэл эзэмэг, Богтаг малгайн суурь



А.



Б.



Гэрэл зураг 27. Дорнод аймаг, Гурванзагал сум, Цагаан чулуут.163-р булш.
Гадаад зохион байгуулалт, олдворууд: Хүрэл толь, Чулуун зүүлт, ясан унжлага